

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2026 оны 3 дугаар
сарын 31-ний өдөр

Дугаар 05

Сүмбэр
сум

**ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙГ ЗӨӨЖ ШИЛЖҮҮЛЭХ, ТҮР СААТУУЛАХ
ХАШАА /БАЙР/-НЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ
ТОГТООХ ТУХАЙ**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14, 35.1.18, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2, 52 дугаар зүйлийн 52.1.2, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Тээврийн хэрэгслийг зөөж, шилжүүлэх, түр саатуулах хашаа /байр/-ны үйл ажиллагааны төлбөрийн хэмжээ”-г хавсралтаар баталсугай.

2.Тогтоолыг Захиргааны ерөнхий хуульд заасан шаардлагыг хангуулж, захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх ажлыг хуулийн хугацаанд зохион байгуулахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нарийн бичгийн дарга (Ж.Оюунбилэг)-т даалгасугай.

3.Уг тогтоол улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдэн, “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтлэгдэж хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг аймгийн Засаг дарга (Т.Бат-Эрдэнэ)-д, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төсөв, санхүү, эдийн засгийн хөгжлийн хороо, Хот суурин дэд бүтцийн хөгжлийн хороод болон Нарийн бичгийн дарга (Ж.Оюунбилэг) нарт үүрэг болгосугай.

4.Энэхүү тогтоол батлагдсантай холбоотой аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн ээлжит бус 8 дугаар хуралдааны 07 дугаар тогтоолыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА

Ш.БИЛЭГГҮМБЭРЭЛ

*Говьсүмбэр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2026 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн ээлжит 12 дугаар
хуралдааны 05 дугаар тогтоолын хавсралт*

**ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙГ ЗӨӨЖ ШИЛЖҮҮЛЭХ,
ТҮР СААТУУЛАХ ХАШАА /БАЙР/-НЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ**

Нэг. Тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх

№	Тээврийн хэрэгслийн төрөл	Төлбөрийн хэмжээ /төгрөгөөр/
1	Мотоцикл	20,000
2	Суудлын автомашин, микро автобус /жолоочоос гадна 8 илүүгүй хүний суудалтай/, бүх жин нь 3500 кг-аас хэтрэхгүй автомашин	50,000
3	Бүх жин нь 5000 кг хүртэл ачааны, 40 хүртэл хүний суудалтай автобус, механизм	55,000
4	Хүнд даацын ачааны автомашин, том оврын автобус, тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл	90,000
10 км-ээс дээш 1 км тутамд 2,000 төгрөгөөр тооцно.		

**Хоёр. Түр саатуулах хашаа /байр/-ны 1 хоногийн төлбөрийн
хэмжээ**

№	Тээврийн хэрэгслийн төрөл	Төлбөрийн хэмжээ /нэг хоногт, /төгрөгөөр/
1	Мотоцикл	3,000
2	Суудлын автомашин, микро автобус /жолоочоос гадна 8 илүүгүй хүний суудалтай/, бүх жин нь 3500 кг-аас хэтрэхгүй автомашин	5,000
3	Бүх жин нь 5000 кг хүртэл ачааны, 40 хүртэл хүний суудалтай автобус, механизм	8,000
4	Хүнд даацын ачааны автомашин, том оврын автобус	15,000
5	Тусгай зориулалтын тээврийн хэрэгсэл	18,000
Гэмт хэрэг, зөрчлийн улмаас түр саатуулагдсан тээврийн хэрэгслийг сар тутам 10 (арав) хоногийн төлбөрийг тооцож авна.		

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 7575 дугаарт бүртгэв

**САНГИЙН САЙД, ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД, СОЁЛ,
СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН САЙДЫН
ХАМТАРСАН ТУШААЛ**

2026 оны 3 дугаар
сарын 27-ны өдөр

Дугаар А/72, А/54, А/140

Улаанбаатар
хот

ЖУРАМ, АРГАЧЛАЛ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Биет бус хөрөнгө болон оюуны өмчийн үнэлгээ хийх журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, “Биет бус хөрөнгө болон оюуны өмчийн үнэлгээ хийх аргачлал”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэхүү тушаалыг үйл ажиллагаандаа мөрдөн, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Оюуны өмчийн газрын дарга Г.Элбэгсайхан, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Баярмагнай, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ нарт тус тус даалгасугай.

САНГИЙН САЙД

Б.ЖАВХЛАН

ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД

Ж.ЭНХБАЯР

СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ ЗАЛУУЧУУДЫН
САЙД

Ч.УНДРАМ

Сангийн сайд, Эдийн засаг, хөгжлийн сайд, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын хамтарсан 2026 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн А/72, А/54, А/140 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралт

БИЕТ БУС ХӨРӨНГӨ БОЛОН ОЮУНЫ ӨМЧИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Биет бус хөрөнгө болон оюуны өмчийн үнэлгээ хийхтэй холбоотой харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2.Биет бус хөрөнгө болон оюуны өмчийн үнэлгээ хийхдээ Хөрөнгийн үнэлгээний тухай хууль, Оюуны өмчийн тухай хууль, Иргэний хууль, Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хууль, Зохиогчийн эрхийн тухай хууль, Патентын тухай хууль, Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль, Үнэлгээний олон улсын стандарт (цаашид “ҮОУС” гэх), үнэлгээний үндэсний стандарт, бусад холбогдох хууль, журам, аргачлалыг баримтална.

1.3.Үнэлгээг Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан үндэслэлээр үнэлгээчин, үнэлгээний хуулийн этгээд (цаашид “үнэлгээчин” гэх) хийнэ.

Хоёр.Хөрөнгийн үнэлгээнд тавигдах шаардлага

2.1.Үнэлгээчин нь үнэлгээ хийхдээ тухайн биет бус хөрөнгө болон оюуны өмчийн онцлог байдлыг судалж, холбогдох хууль, тогтоомж, стандартад заасан бэлтгэл ажлыг хангасан байх бөгөөд дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

2.1.1.үнэлгээчний эрх, хөрөнгийн үнэлгээний үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байх;

2.1.2.оюуны өмчийн үнэлгээ хийх үнэлгээчин нь Оюуны өмчийн тухай хуулийн 21.1-д заасан сургалтад хамрагдаж, гэрчилгээ авч, 21.3-т заасан оюуны өмчийн үнэлгээ хийх эрх бүхий этгээдийн жагсаалтад бүртгэгдсэн байх;

2.1.3.Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу үнэлгээний хараат бус байдлыг хангасан байх.

2.2.Биет бус хөрөнгө болон оюуны өмчийн үнэлгээнд “Биет бус хөрөнгө болон оюуны өмчийн үнэлгээ хийх аргачлал”-ыг баримтална.

2.3.Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 23.1.4, 23.1.5 дахь заалтад заасан олон улсын хөрөнгийн үнэлгээний тайлагналын стандартын дагуу мэргэжлийн байгууллагаас боловсруулан гаргасан гэрээт ажлын захидал, үнэлгээний шалгах хуудас зэрэг үлгэрчилсэн загвар, заавар, хэрэглээний тайлбар, зөвлөмжийг ашиглан биет бус хөрөнгө болон оюуны өмчийг үнэлнэ.

2.4. Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 5.1.1-д заасан үндэслэлээр үнэлгээ хийх бол ажлын цар хүрээ, хийх ажлын төлөвлөгөөнд тулгуурлан бичгээр байгуулсан гэрээний үндсэн дээр гүйцэтгэнэ.

2.5. Үнэлгээний зорилго, зориулалт, хэрэглэх үнэ цэнийн суурь, үнэлгээний өдөр, зорилтот хэрэглэгч, үнэлгээ хийх хугацаа, үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхтэй холбоотой гарах зардал, үнэлгээний үр дүнг хэрэглэх нөхцөл зэрэг ажлын цар хүрээг үйлчлүүлэгчид танилцуулан гэрээт ажлын захидлаар баталгаажуулна.

2.6. Биет бус хөрөнгө болон оюуны өмчийн онцлог, тодорхой бус, нарийн төвөгтэй байдлыг харгалзан, оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, холбогдох салбарын мэргэжилтнийг татан оролцуулж болно.

2.7. Оюуны өмчийн хүчинтэй хугацаа, төлөвийн мэдээллийг оюуны өмчийн мэдээллийн сан, оюуны өмчийн газраас эрхлэн гаргасан албан ёсны хэвлэлийн мэдээлэлтэй тулган баталгаажуулж үнэлгээнд хэрэглэж болно.

2.8. Үнэлгээчин нь шаардлагатай тохиолдолд оюуны өмчийн газар, оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оюуны өмчтэй холбоотой лавлагаа, дүгнэлт мэдээллийг гаргуулан авах бөгөөд хэрэв оюуны өмчийн зөрчилтэй бол зөрчлийг арилгасны дараа үнэлгээ хийнэ.

Гурав. Хөрөнгийн үнэлгээний тайлан

3.1. Үнэлгээний тайланг Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 8.2-т заасан шаардлага, ҮОУС, үнэлгээний үндэсний стандартад нийцүүлэн бэлтгэнэ.

3.2. Хөрөнгийн үнэлгээний тайланд мэргэжлийн байгууллагын тайлангийн мэдээллийн санд бүртгүүлсэн цахим дугаарыг хэрэглэнэ.

3.3. Хөрөнгийн үнэлгээний тайланг үйлчлүүлэгчид хүлээлгэн өгснөөс хойш ажлын 5 өдрийн дотор Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 25.2-т заасан мэдээллийг хөрөнгийн үнэлгээний мэдээллийн санд оруулна.

3.4. Хууль, дүрэм журмыг баримтлан үнэлгээ хийх явцад ҮОУС-д зааснаас өөр шаардлага тавигдан гажилт үүссэн тохиолдолд үнэлгээний тайланд тодруулга хийн, баримтжуулна.

3.5. Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 5.2-т заасан үнэлгээг хийхдээ ҮОУС-д заасны дагуу хөрөнгийн үнэлгээний тухайн ажилд оролцоогүй, зохих туршлага, мэдлэг бүхий үнэлгээний хуулийн этгээдээр үнэлгээний нягтлах шалгалт хийлгэсэн байна.

3.6. Хөрөнгийн үнэлгээний тайланг бичгээр үйлдэх ба гүйцэтгэх захирал, гүйцэтгэсэн үнэлгээчин гарын үсэг зурж, тамга, тэмдэг даран баталгаажуулна.

Дөрөв. Үнэлгээний үйл ажиллагаанд тавих хяналт, шалгалт

4.1. Үнэлгээчин нь хөрөнгийн үнэлгээний үйл ажиллагаандаа дотоод чанарын хяналтыг хэрэгжүүлнэ.

4.2. Үнэлгээчин нь хөрөнгийн үнэлгээ хийхэд ашигласан орц мэдээлэл болох үйлчлүүлэгчээс хүлээн авсан мэдээлэл, цуглуулсан судалгаа, нотолгоо баримт мэдээллийг үнэлгээний тайлангийн хамт архивын нэгж болгон хадгална.

4.3. Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 13.2-т заасан нөхцөл, шаардлагыг зөрчсөн гэж үзвэл захиалагч, үйлчлүүлэгч болон гуравдагч этгээд нь хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллагад гомдол гарган шийдвэрлүүлнэ.

4.4. Үнэлгээний тайлантай холбоотой гомдол, маргааныг хөрөнгийн үнэлгээний мэргэжлийн байгууллагын дэргэдэх Мэргэжлийн болон ёс зүйн зөвлөл хянан шийдвэрлэнэ.

Сангийн сайд, Эдийн засаг, хөгжлийн сайд, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын хамтарсан 2026 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн А/72, А/54, А/140 дүгээр тушаалын хоёрдугаар хавсралт

БИЕТ БУС ХӨРӨНГӨ БОЛОН ОЮУНЫ ӨМЧИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ АРГАЧЛАЛ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Биет бус хөрөнгө болон оюуны өмчийн үнэлгээ хийхэд энэхүү аргачлалыг баримтална.

1.2.Бизнес дэх биет бус хөрөнгийг үнэлэхдээ Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын хамтарсан тушаалаар батлагдсан “Бизнесийн үнэлгээ хийх аргачлал”-ыг хамт хэрэглэж болно.

Хоёр.Биет бус хөрөнгө болон оюуны өмчийн төрөл

2.1.Биет бус хөрөнгийн үнэлгээнд Үнэлгээний олон улсын стандарт (цаашид “ҮОУС” гэх)-д заасан дараах төрлийн хөрөнгийг хамруулна.
Үүнд:

- 2.1.1.маркетингтай холбоотой биет бус хөрөнгө;
- 2.1.2.худалдан авагчтай холбоотой биет бус хөрөнгө;
- 2.1.3.урлагтай холбоотой биет бус хөрөнгө;
- 2.1.4.гэрээтэй холбоотой биет бус хөрөнгө;
- 2.1.5.технологитой холбоотой биет бус хөрөнгө.

2.2.Оюуны өмчийн үнэлгээнд Оюуны өмчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан дараах төрлийн хөрөнгийг хамруулна.
Үүнд:

- 2.2.1.зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрх;
- 2.2.2.патент, түүний төрлүүд;
- 2.2.3.ашигтай загвар;
- 2.2.4.бүтээгдэхүүний загвар;
- 2.2.5.барааны тэмдэг, түүний төрлүүд;
- 2.2.6.газар зүйн заалт.

2.3.Үнэлгээчин нь үнэлж буй биет бус хөрөнгө болон оюуны өмчийг бусад хөрөнгө, эсхүл бизнесээс салгах боломжтой эсэхийг нягталж, зөв ангилан тодорхойлсон байна.

Гурав.Биет бус хөрөнгө болон оюуны өмчийн үнэлгээ хийх ажлын үе шат

3.1.Үнэлгээчин нь үнэлгээ хийхдээ дараах үе шатыг баримтална.
Үүнд:

3.1.1.үнэлгээний ажлын зорилго ба зориулалт, зориулагдсан хэрэглээнд нийцсэн үнэ цэнийн суурийг сонгож, үнэлгээний ажлын цар

хүрээг тодорхойлох;

3.1.2.үнэлгээний багийн бүрэлдэхүүн, оролцоо, төлөвлөгөө, төсөв, ажлын хуваарийг боловсруулах;

3.1.3.үнэлж буй биет бус хөрөнгө болон оюуны өмчийг тодорхойлох;

3.1.4.үйлчлүүлэгчтэй гэрээ байгуулж, гэрээт ажлын нөхцөлийг тохиролцож гэрээт ажлын захидлаар баталгаажуулах;

3.1.5.шаардлагатай мэдээллийн судалгаа хийж, мэдээллийн найдвартай, бодитой байдлыг нягтлан шинжилгээ хийх;

3.1.6.биет бус хөрөнгө болон оюуны өмчийн онцлог шинж чанаруудыг тодорхойлох;

3.1.7.үнэлгээний тохиромжтой хандлага, аргуудыг сонгож, үнэ цэнийн тооцоолол хийх;

3.1.8.үнэлгээний үр дүнг нэгтгэн хөрөнгийн үнэлгээний тайлан бэлтгэж, үйлчлүүлэгчид хүргүүлэх.

3.2.Үнэлгээчин нь ҮОУС-ын дагуу дараах үнэ цэнийн сууриудаас үнэлгээний зорилгод тохирох суурийг сонгон хэрэглэнэ. Үүнд:

3.2.1.зах зээлийн үнэ цэнийн суурь;

3.2.2.бодит үнэ цэнийн суурь;

3.2.3.зах зээлийн түрээсийн төлбөрийн үнэ цэнийн суурь;

3.2.4.тэгш шударга үнэ цэнийн суурь;

3.2.5.хөрөнгө оруулалтын үнэ цэнийн суурь;

3.2.6.өргөжилтийн хэмнэлтийн үнэ цэнийн суурь;

3.2.7.устгалын үнэ цэнийн суурь;

3.2.8.бусад.

3.3.Үнэлгээчин нь дор дурдсан мэдээллийн судалгаа хийнэ. Үүнд:

3.3.1.биет бус хөрөнгө болон оюуны өмчид хамаарах бүтээгдэхүүн, үйлчилгээ, бүтээл, туурвил, тэдгээрийн хэрэглэгчийн зан төлөвийн, өрсөлдөгчийн, зах зээлийн, бизнесийн судалгаа, мэдээлэл;

3.3.2.ижил, төстэй хөрөнгө, хөрөнгийн эрх шилжүүлэх, ашиглуулах гэрээтэй холбоотой зах зээлийн мэдээлэл;

3.3.3.биетбусхөрөнгөболонюуныөмчийнөнөөгийннашиглалтын байдал, санхүүгийн тайлан, түүний тодруулга, өртөг зардлын хэмнэлт, өгөөж, үр ашиг, үйл ажиллагааны талаар үйлчлүүлэгчийн бэлтгэсэн албан ёсны баримт, мэдээлэл;

3.3.4.биет бус хөрөнгө болон оюуны өмчийн түүхэн, ирээдүйн ашиглалтын талаар зохиогч, хэрэглэгч, эрх эзэмшигчийн бэлтгэсэн төлөвлөгөө, ярилцлага тодруулга, тэмдэглэл;

3.3.5.оюуны өмчийн эрхийн хамгаалалтын үндэсний болон олон улсын бүртгэл, салбарын хууль, олон улсын конвенц, хууль, эрх зүйн орчны судалгаа;

3.3.6.Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай болон Байгууллагын нууцын тухай хуульд зааснаас бусад мэдээлэл.

3.4.Үнэлгээчин нь дараах хүчин зүйлийг харгалзан үнэлгээ хийхэд тохиромжтой аргыг сонгоно. Үүнд:

- 3.4.1.үнэлгээний зорилго;
- 3.4.2.хөрөнгийн төрөл, онцлог;
- 3.4.3.үнэлгээний гэрээт ажлын нөхцөл, зориулагдсан хэрэглээ;
- 3.4.4.үнэ цэнийн суурь;
- 3.4.5.мэдээллийн найдвартай, бэлэн олдоцтой байдал;
- 3.4.6.бусад.

3.5.Цуглуулсан мэдээллийн бодитой, найдвартай байдлыг үнэлж, дүгнэхийн тулд дараах шинжилгээнүүдийг хийвэл зохино. Үүнд:

- 3.5.1.макро эдийн засгийн, салбарын, зах зээлийн шинжилгээ;
- 3.5.2.оюуны өмчийн хамгаалалтын байдал, урьдчилсан хайлт;
- 3.5.3.эрхийн шимтгэлийн хувийн шинжилгээ;
- 3.5.4.санхүүгийн тайлангийн шинжилгээ;
- 3.5.5.бусад.

Дөрөв.Үнэлгээ хийх хандлага, аргууд

4.1.Үнэлгээчин нь зах зээлийн, орлогын, өртгийн хандлагын тохиромжтой аргыг ашиглан биет бус хөрөнгө болон оюуны өмчийн үнэ цэнийг тодорхойлно.

4.2.Үнэлгээний гэрээт ажлын нөхцөл, үнэлгээний зорилго, орц мэдээллийн найдвартай, бэлэн олдоцтой байдал, үнэлгээний аргыг хэрэглэх нөхцөлийг харгалзан хэд хэдэн аргыг сонгон хэрэглэсэн бол аргуудын үр дүнг шинжлэн тохируулж, ач холбогдлын хувийн жингээр жинлэх замаар үнэ цэнийн эцсийн дүгнэлтийг гаргана.

№	Хандлага, аргын нэр	Тооцоолсон дүн (Pi), мян.төг	Ач холбогдлын хувийн жин (Wi)	Дүн, мян.төг $P=\sum(Pi*Wi)$
1	Арга 1			
2	Арга 2			
3	Арга 3			

4.3.Бизнесийн үнэ цэнийн биет бус хөрөнгөд ногдох үнэ цэнээс тодорхойлогдох биет бус хөрөнгийн үнэ цэнийг хасаж тодорхойлогдохгүй биет бус хөрөнгө (гүүдвил)-ийн үнэ цэнийг тооцно.

Тав.Зах зээлийн хандлага

5.1.Зах зээлийн хандлагыг үнэлж байгаа биет бус хөрөнгө болон оюуны өмчтэй жишиж болох ижил, эсхүл төстэй хөрөнгийн арилжааны мэдээлэл бэлэн, олдоцтой байгаа тохиолдолд хэрэглэнэ.

5.2.Зах зээлийн хандлагаар биет бус хөрөнгө болон оюуны өмчийн үнэлгээ хийхдээ түүний төрөл, онцлог, ялгаатай шинж байдлыг харгалзан жиших ажил гүйлгээний аргыг хэрэглэнэ.

5.3.Жиших ажил гүйлгээний аргаар үнэлгээ хийхэд дараах үе шатыг баримтална. Үүнд:

5.3.1.жишиж болохуйц зах зээлийн арилжааны, эрх шилжүүлэх мэдээлэл, судалгаанд үндэслэн үнэлгээний гол хэмжигдэхүүнийг тодорхойлох;

5.3.2.харьцуулалт хийх нэгжийг тодорхойлох;

5.3.3.жиших хөрөнгө болон үнэлж байгаа хөрөнгийн хоорондох ижил, төстэй ба ялгаатай талуудын тоон болон чанарын зэрэгцүүлсэн шинжилгээг хийх;

5.3.4.зэрэгцүүлсэн шинжилгээг үндэслэн жиших хөрөнгө тус бүрийн үнэлгээний гол хэмжигдэхүүнд тохируулга хийн тохируулга хийгдсэн жиших үнийг тодорхойлох;

5.3.5.тохируулга хийгдсэн жиших үнийг ач холбогдлын хувиар жинлэн, эсхүл дундажлан биет бус хөрөнгө болон оюуны өмчийн үнэ цэнийг тодорхойлно.

5.4.Үнэлгээчин нь үнэлгээний гол хэмжигдэхүүнд дараах мэдээллийг авч үзнэ:

5.4.1.биет бус хөрөнгийн төрөл, оюуны өмчийн эрхийн төрөл;

5.4.2.оюуны өмчийн эрхийн хамгаалалт хүчинтэй газар зүйн бүс, нутаг дэвсгэр, улс орон (үндэсний, олон улсын, тухайн улсын);

5.4.3.эрхийн хамгаалалтын хүрээ (ангилал, тодорхойлолт, томьёолол);

5.4.4.эрхийн хүчинтэй болон эдийн засгийн ашиглалтын хугацаа;

5.4.5.биет бус хөрөнгөд хамаарах бүтээгдэхүүн, үйлчилгээ, бизнесийн салбарын ангилал, түүхэн болон хүлээгдэж буй өсөлтийн хувь;

5.4.6.биет бус хөрөнгийн өгөөж бий болгох чадвар боломж, ашигт байдал;

5.4.7.роялти хувь;

5.4.8.гэрээний төрөл, хугацаа, онцлог нөхцөл ба хязгаарлалт, төлбөрийн нөхцөл;

5.4.9.бусад.

Зургаа.Орлогын хандлага

6.1.Орлогын хандлагыг дараах тохиолдолд хэрэглэнэ. Үүнд:

6.1.1.хөрөнгийн орлого бий болгох чадвар нь үнэ цэнэд нөлөөлөх гол хүчин зүйл байх;

6.1.2.ирээдүйн орлогын дүн ба орлого бий болгох хугацааны талаар үл үндэслэлтэй төсөөлөл хийх боломжтой байх;

6.1.3.орлого бий болгож хараахан эхлээгүй боловч орлого бий болгоно гэж төсөөлсөн байх.

6.2.Орлогын хандлагаар биет бус хөрөнгө болон оюуны өмчийн үнэлгээ хийхдээ илүүдэл ашгийн арга, эрхийн шимтгэлээс чөлөөлөх арга, урамшуулалт ашгийн арга буюу орших ба үл орших арга, грийнфиелдийн (буюу “ногоон тал”-ын) арга, дистрибьютерийн аргын аль тохиромжтойг сонгон хэрэглэнэ.

6.3.Илүүдэл ашгийн аргаар биет бус хөрөнгө болон оюуны өмчийг үнэлэхдээ дараах үе шатыг баримтална:

6.3.1.биет бус хөрөнгө, оюуны өмч болон мөнгөн гүйлгээг бий болгоход оролцох бусад хөрөнгийн (цаашид “хувь нэмэр оруулагч хөрөнгө” гэх) ирээдүйн орлогын дүн ба хугацааны төсөөллийг зохиох;

6.3.2.биет бус хөрөнгө, оюуны өмч болон хувь нэмэр оруулагч хөрөнгийн ирээдүйн орлогыг бий болгоход шаардлагатай зардлын дүн ба хугацааны төсөөллийг зохиох;

6.3.3.биет бус хөрөнгө, оюуны өмчийг шинээр бүтээн бий болгоход оролцдоггүй зардлыг хасаж, төсөөлсөн зардлын дүнг тохируулах;

6.3.4.төсөөлсөн орлого ба зардлын дүнд ажлын капитал, үндсэн хөрөнгө, ажиллах хүчин, үнэлж буй биет бус хөрөнгө болон оюуны өмчөөс бусад тодорхойлсон биет бус хөрөнгө зэрэг хувь нэмэр оруулагч хөрөнгийг тодорхойлох;

6.3.5.хувь нэмрээ оруулагч хөрөнгө нэг бүрийн хувьд тухайн хөрөнгөтэй холбоотой эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан өгөөжийн зохих хувь хэмжээг тодорхойлох;

6.3.6.төсөөллийн хугацааны үе бүрийн төсөөлсөн нийт ашгаас хувь нэмрээ оруулагч хөрөнгүүдэд хамаарах өгөөжийг хасан үнэлж байгаа биет бус хөрөнгө, оюуны өмчид ногдох өгөөжийн дүнг тодорхойлох;

6.3.7.биет бус хөрөнгө, оюуны өмчид ногдох өгөөжийн дүнг тохиромжтой хувиар хорогдуулан биет бус хөрөнгө, оюуны өмчийн үнэ цэнийг тодорхойлно;

6.3.8.санхүүгийн тайлагналын болон татварын зориулалтаар үнэлгээ хийхдээ хорогдуулгын зардлын татварын хэмнэлтийг тооцож болно.

6.4.Энэ аргачлалын 6.3.3-т заасан биет бус хөрөнгө болон оюуны өмчийг шинээр бүтээн бий болгох зардалд дараах зардлыг хамруулахгүй:

6.4.1. шинэ технологийг хөгжүүлэн боловсруулахтай холбоотой судалгаа хөгжүүлэлтийн зардал;

6.4.2. шинэ худалдан авагчдыг олж авахтай холбоотой маркетингийн зардал.

6.5. Эрхийн шимтгэлээс чөлөөлөх аргаар биет бус хөрөнгө болон оюуны өмчийн үнэлгээ хийхдээ дараах үе шатыг баримтална:

6.5.1. үнэлж буй биет бус хөрөнгө болон оюуны өмчийн ашиглалтын хугацаагаар орлогын төсөөллийг боловсруулах;

6.5.2. үнэлж буй биет бус хөрөнгө болон оюуны өмчийн эрхийн шимтгэлийн хувийг тодорхойлох;

6.5.3. эрхийн шимтгэлийн хувийг үндэслэн бусдад төлөхгүй эрхийн шимтгэлийн төлбөрүүдийг тооцоолох;

6.5.4. үнэлж буй хөрөнгө болон жиших хөрөнгийн хувьд гэрээний аливаа хязгаарлалт, урьдчилгаа төлбөр, лицензээр эзэмшихтэй холбоотой засвар үйлчилгээ, маркетингийн зардлыг лицензийн гэрээгээр хүлээн авагч эсхүл лиценз олгогчийн аль нь хариуцаж байгааг харгалзан нэмэлт зардлуудыг тооцоолох;

6.5.5. хэрэв төсөөлсөн өртөг ба эрхийн шимтгэлийн төлбөрүүд нь татвараас хасагдах зардалд тооцогддог бол тухайн хөрөнгөтэй холбоотой татварын хэмнэлтийг тодорхойлох;

6.5.6. үнэлж буй биет бус хөрөнгө болон оюуны өмчийн төсөөлсөн орлогыг тохиромжтой хувиар хорогдуулах буюу тухайн хөрөнгөтэй холбоотой хэмнэлтүүдийг капиталжуулан өнөөгийн үнэ цэнийг тодорхойлох.

6.6. Урамшуулалт ашгийн арга буюу “оршин байх ба үл орших” аргаар биет бус хөрөнгө болон оюуны өмчийн үнэлгээ хийхдээ дор дурдсан үе шатыг баримтална:

6.6.1. үнэлж байгаа биет бус хөрөнгө болон оюуны өмчийг оролцуулан бүх хөрөнгийг ашиглана гэж тооцон “оршин байх” хувилбараар ирээдүйн мөнгөн гүйлгээг зохиох;

6.6.2. ирээдүйн мөнгөн гүйлгээг тохиромжтой хувиар хорогдуулан “оршин байх” хувилбараар бизнесийн үнэ цэнийг тооцоолох;

6.6.3. үнэлж байгаа биет бус хөрөнгө болон оюуны өмчөөс бусад бүх хөрөнгийг ашиглана гэж тооцон “үл орших” хувилбараар ирээдүйн мөнгөн гүйлгээг зохиох;

6.6.4. ирээдүйн мөнгөн гүйлгээг тохиромжтой хувиар хорогдуулан “үл орших” хувилбараар бизнесийн үнэ цэнийг тооцоолох;

6.6.5. “оршин байх” хувилбараар тооцоолсон бизнесийн үнэ цэнээс “үл орших” хувилбараар тооцоолсон бизнесийн үнэ цэнийг хасаж үнэлж буй биет бус хөрөнгө болон оюуны өмчийн үнэ цэнийг тодорхойлно.

6.7.“Оршин байх” болон “үл орших” хувилбарт ижил хорогдуулах хувийг ашиглах бөгөөд хувилбаруудын үр дүнгийн зөрүүг магадлалын хувиар жинлэж болно.

6.8.Грийнфиелдийн арга буюу “ногоон тал”-ын аргаар биет бус хөрөнгө болон оюуны өмчийг үнэлгээ хийхдээ дараах үе шатыг баримтална:

6.8.1.үнэлж байгаа биет бус хөрөнгө болон оюуны өмч нь бизнесийн өмчилж буй цорын ганц хөрөнгө гэдэг төсөөлөлд үндэслэн мөнгөн урсгалын төсөөллийг бизнес тогтворжих хүртэлх хугацаагаар боловсруулна;

6.8.2.бизнесийн үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгө, биет бус хөрөнгийг худалдан авах, барьж байгуулах, түрээслэхтэй холбоотой зардлыг хасаж мөнгөн урсгалыг тохируулна;

6.8.3.тохируулсан мөнгөн урсгалыг тохиромжтой хувиар хорогдуулж биет бус хөрөнгө болон оюуны өмчийн үнэ цэнийг тодорхойлно.

6.9.Дистрибьютерийн арга буюу хэсэгчлэн хуваах аргаар биет бус хөрөнгө болон оюуны өмчийн үнэлгээ хийхдээ дараах үе шатыг баримтална:

6.9.1.одоо байгаа худалдан авагчдын тооны өөрчлөлтийг харгалзан тооцож орлогын төсөөллийг боловсруулах;

6.9.2.үнэлж байгаа бизнестэй төсөөтэй худалдан авагчийн харилцаа бүхий жиших дистрибьютерүүдийг тодорхойлж, тэдгээрийн олох ашгийн хувь хэмжээг тооцоолох;

6.9.3.уг тодорхойлсон дистрибьютерийн олох ашгийн хувь хэмжээг орлогын төсөөлөлд хэрэглэх;

6.9.4.төсөөлсөн орлого ба зардалтай холбоотой хувь нэмрээ оруулагч хөрөнгүүдийг тодорхойлох;

6.9.5.хувь нэмрээ оруулагч хөрөнгө тус бүрийн өгөөжийн хувийг тооцоолох;

6.9.6.уг дистрибьютерийн төсөөлсөн ашгаас хувь нэмрээ оруулагч хөрөнгийн өгөөжийг хасаж тухайн үнэлж байгаа биет бус хөрөнгө болон оюуны өмчид хамаарах илүүдэл ашгийг тооцоолох;

6.9.7.илүүдэл ашгийн ирээдүйн мөнгөн гүйлгээг хорогдуулж биет бус хөрөнгө болон оюуны өмчийн өнөөгийн үнэ цэнийг тодорхойлох.

6.10.Үнэлгээчин нь хорогдуулах хувийг тодорхойлохдоо үнэлж байгаа биет бус хөрөнгө болон оюуны өмчтэй төстэй хөрөнгийн стандарт хэмжигдэхүүн (бенчмарк)-ийг харгалзан үзсэн байна.

6.11.Биет бус хөрөнгө, оюуны өмчийн төрлөөс хамаарч хуулийн хүчинтэй хугацаанаас гадна технологийн, үүрэг ажиллагааны,

эдийн засгийн хоцрогдол болон уг хөрөнгөд хамаарах бүтээгдэхүүн үйлчилгээний амьдралын мөчлөг зэрэг хүчин зүйлсийг харгалзан эдийн засгийн ашиглалтын хугацааг тодорхойлно.

Долоо.Өртгийн хандлага

7.1.Өртгийн хандлагыг дараах тохиолдолд хэрэглэнэ:

7.1.1.хуулийн саад хязгаарлалтгүйгээр үнэлж байгаа биет бус хөрөнгө болон оюуны өмчтэй бараг ижил хэрэгцээт чанар бүхий хөрөнгийг дахин бий болгох боломжтой байх;

7.1.2.үнэлж байгаа биет бус хөрөнгө болон оюуны өмчийг дахин шинээр бий болгох боломжтой байх;

7.1.3.биет бус хөрөнгө, оюуны өмч нь орлогыг шууд бий болгодоггүй бөгөөд тухайн хөрөнгийн өвөрмөц онцлог нь орлогын хандлага, эсхүл зах зээлийн хандлагыг ашиглах ямар ч боломжгүй байх;

7.1.4.хэрэглэж буй үнэ цэнийн суурь нь орлуулалтын өртөгт суурилан орлуулалтын үнэ цэнийг тодорхойлох.

7.2.Өртгийн хандлагаар биет бус хөрөнгө болон оюуны өмчийн үнэлгээг хийхдээ орлуулалтын өртгийн аргыг хэрэглэнэ.

7.3.Орлуулалтын өртгийн аргаар биет бус хөрөнгө болон оюуны өмчийг үнэлэхдээ дараах үе шатыг баримтална:

7.3.1.үнэлж байгаа биет бус хөрөнгө болон оюуны өмчийн ашиглалтыг орлуулах шууд болон шууд бус зардлуудыг тодорхойлох;

7.3.2.үнэлж байгаа биет бус хөрөнгө болон оюуны өмч нь хоцрогдолд ордог тохиолдолд эдийн засгийн хоцрогдлыг тодорхойлох;

7.3.3.тохиромжтой бол ашгийн нэмэгдлийг тодорхойлох;

7.3.4.шаардлагатай тохиолдолд алдагдсан боломжийн өртгийг тодорхойлох;

7.3.5.шууд болон шууд бус зардлын дүнгээс эдийн засгийн хоцрогдлыг хасаж, ашгийн нэмэгдэл болон алдагдсан боломжийн өртгийг нэмж үнэлж байгаа биет бус хөрөнгө болон оюуны өмчийн үнэ цэнийг тодорхойлох.

Найм.Хөрөнгийн үнэлгээний тайлан

8.1.Үнэлгээчин нь биет бус хөрөнгө болон оюуны өмчийн үнэлгээ хийсэн аргын сонголт, үнэлгээний үр дүнг эцэслэхэд хэрэглэсэн жинлэлт, үнэлгээний тооцоололд хэрэглэсэн гол хүчин зүйлүүдийн тодорхойлолт, тайлбар, судалгаа шинжилгээний дүгнэлт, үнэлгээний тооцооллын үндэслэлийг Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 8.3-т заасны дагуу үнэлгээний тайланд тодорхой тусгасан байна.

8.2.Үнэлгээний тайланд үнэлгээний үр дүнг хэрэглэх ба хязгаарлах нөхцөл, гажилт, хэрэглэсэн төсөөлөл нь нотлогдохуйц, үндэслэлтэй байна.

8.3.Салбарын мэргэжилтэн, оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийг үнэлгээний ажилд татан оролцуулсан тохиолдолд гаргасан дүгнэлт, тодорхойлолт, мэдээлэл, нягтлах шалгалтын тайланг уг үнэлгээний тайланд хавсаргана.

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 3 дугаар
сарын 31-ний өдөр

Дугаар 134

Өлгий
сум

УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 8 дугаар хуралдаанаас **ТОГТООХ** нь:

1.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35.1.4-35.1.13, 35.1.15-35.1.18, 35.1.21, 35.1.22 дахь заалт, 35.4, 35.5 дахь хэсэгт заасан тэмдэгтийн хураамжийн хэмжээг шинэчлэн хавсралтаар баталсугай.

2.Шийдвэрийг холбогдох байгууллага, ард иргэдэд сурталчлан таниулж, батлагдсан хувь хэмжээгээр хураамжийг төвлөрүүлэн ажиллахыг аймгийн Засаг дарга (Е.Зангар), сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 76 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж холбогдох өөрчлөлтийг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, Эрх зүйн мэдээллийн сангийн Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба /М.Баршагүл/-д үүрэг болгосугай.

ДАРГА

А.БЕГАРЫС

*Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны
3 дугаар сарын 31-ний өдрийн ээлжит 8 дугаар
хуралдааны 134 дүгээр тогтоолын хавсралт*

УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭ

1. Аймаг, сумдын төрийн захиргааны байгууллага, Засаг даргаас тусгай зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

1.1. Агаарт бохирдуулах бодис гаргадаг, физикийн хортой нөлөөлөл үзүүлдэг үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход 500 000 төгрөг;

1.2. Тамхи худалдах тусгай зөвшөөрөл олгоход 100 000 төгрөг;

1.3. Ус хэрэглэгчид газрын доорх ус ашиглалтын цооног өрөмдөх зөвшөөрөл олгоход 200 000 төгрөг;

1.4. Ус ашиглагчтай гэрээ байгуулж, 100 шоо метрээс бага ус ашиглуулах гэрчилгээ олгоход гэрээний жил тутамд 50 000 төгрөг, гэрээг сунгахад 30 000 төгрөг;

1.5. Усны барилга байгууламж гэрээгээр эзэмших, ашиглах эрх олгох, эрх сунгахад 60 000 төгрөг;

1.6. Ан амьтныг эзэмших зөвшөөрөл олгоход 80 000 төгрөг;

1.7. Нэн ховор, ховор амьтныг судалгаа, шинжилгээ, соёл, урлаг, гоо зүйн зориулалтаар /ажиглаж судлах, тэмдэг тавих, зурах, зураг авах зэрэг хэлбэрээр/ амьтныг гэмтэлгүйгээр амьдрах орчныг нь алдагдуулалгүйгээр ашиглах зөвшөөрөл олгоход 60 000 төгрөг;

1.8. Хөрс бүрдүүлэх, байгалийг ариутгах, ургамалд тоос хүртээх зэрэгт амьтны амьдралын үйл ажиллагааны хэрэгтэй чанарыг ашиглахдаа амьтанд гэмтэл учруулахгүйгээр гүйцэтгэх ба ийм хэлбэрээр амьтныг ашиглах зөвшөөрлийг олгоход 10 000 төгрөг;

1.9. Ан амьтан, ургамал тэдгээрийн гаралтай түүхий эдийг худалдах иргэн, хуулийн этгээдэд суман дахь байгаль хамгаалагч гарал үүслийн тодорхойлолт олгоход 5000 төгрөг;

1.10. Үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын ан амьтан агнах, барих гэрээ байгуулахад 800 000 төгрөг;

1.11. Ховор ургамлыг ахуйн болон судалгаа, шинжилгээний зориулалтаар ашиглах зөвшөөрөл олгоход килограмм тутамд 3000 төгрөг;

1.12. Элбэг ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглах зөвшөөрөл олгоход 2000 төгрөг;

1.13. Элбэг ургамлыг гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээд түүж бэлтгэхэд нойтон жингийн килограмм тутамд 10 000 төгрөг;

1.14.Ойн дагалт нөөцийг ашиглах эрхийн бичиг олгоход 0-10 килограмм бол 1500 төгрөг, 10 килограммаас дээш бол 10 килограммаас дээш тооцсон хэмжээний килограмм тутамд 100 төгрөг нэмж;

1.15.Малын удам гарвалийн болон эрүүл мэндийн гэрчилгээ, шилжилт хөдөлгөөний тодорхойлолт, мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээ эрхлэх итгэмжлэлийн гэрчилгээ, мал, үржүүлгийн бүтээгдэхүүний гарал үүслийн тодорхойлолт, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанарын гэрчилгээ олгоход 5000 төгрөг;

1.16.Рашаан ашиглах, савлах зөвшөөрөл олгоход 300 000 төгрөг.

2.Сүүн бүтээгдэхүүнээр нэрсэн шимийн архи үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл олгоход 50 000 төгрөгийн тэмдэгтийн хураамж хураана.

3.Бэлтгэсэн мод, модон материалд гарал үүслийн гэрчилгээ олгоход дор дурдсан хэмжээгээр тэмдэгтийн хураамж хураана:

3.1.Мод, модон түүхий эдийн гарал үүслийн гэрчилгээ олгох

Хураамжийн хэмжээг тооцох нэгж	Хураамжийн хэмжээ /төгрөгөөр/
6м ³ хүртэл	3000
6-10м ³ хүртэл	4500
10-20м ³ хүртэл	6000
20-60м ³ хүртэл	15000

3.2.Ойгоос хэрэглээний мод бэлтгэх эрхийн бичиг олгоход:

Хураамжийн хэмжээг тооцох нэгж	Хураамжийн хэмжээ /төгрөгөөр/
8м ³ хүртэл	4500
8-10м ³ хүртэл	6000
10-20м ³ хүртэл	10500
20-30м ³ хүртэл	15000

3.3.Ойгоос түлээ бэлтгэх эрхийн бичиг олгоход:

Хураамжийн хэмжээг тооцох нэгж	Хураамжийн доод хэмжээ /төгрөгөөр/
0-10м ³	3000
10-20м ³	3600
20-30м ³	4500

3.4.Арчилгаа, цэвэрлэгээний журмаар бэлтгэсэн модонд гарал үүслийн гэрчилгээ олгоход 0-10 куб метр бол 2000 төгрөг, 10 куб метрээс дээш бол 2000 төгрөг дээр 10-аас дээш сийрэг куб метр тутамд 150 төгрөг нэмж;

3.5.Ойгоос бэлтгэсэн гуалин, шургааг, дүнз, зүсмэл материалыг өөр аймаг, сум, хот, суурингийн хооронд тээвэрлэх, худалдах, мод, модон материалын гарал үүслийн гэрчилгээ олгоход 0-10 куб метр бол 2000 төгрөг, 10 куб метрээс дээш бол 2000 төгрөг дээр 10-аас дээш куб метр тутамд 150 төгрөг нэмж;

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 7577 дугаарт бүртгэв.

ӨМНӨГОВЬ АЙМАГ ХҮРМЭН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 3 дугаар
сарын 13-ны өдөр

Дугаар 7/06

Хүрмэн
сум

ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.4 дэх хэсэг, Сангийн сайд, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын хамтарсан “Аргачлал батлах тухай” 2018 оны 192, А/243 дугаар тушаалыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Хүрмэн сумын нутаг дэвсгэрт мөрдөх хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг шинэчлэн хавсралтаар баталсугай.

2.Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг батлагдсан үнэ тарифын дагуу иргэн, аж ахуй нэгж, албан байгууллагаас хураан барагдуулж, орон нутгийн төсөвт цаг хугацаанд нь төвлөрүүлэх, зохих журмын дагуу зарцуулж ажиллахыг сумын Засаг дарга (Г.Амарбаяр)-д үүрэг болгосугай.

3.Тогтоолыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхийг сумын Засаг дарга (Г.Амарбаяр)-д даалгасугай.

4.Энэхүү тогтоолыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

5.Уг тогтоол батлагдсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 14/11 тоот тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ХУРЛЫН ДАРГА

Т.ЦЭЦЭГДАРИНАА

*Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2026 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн
7/06 дугаар тогтоолын хавсралт*

**ХҮРМЭН СУМЫН ИРГЭН, АЖ АХУЙ НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН ХОГ
ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭ**

№	Хог хаягдал гаргах эх уусвэр	Хэмжих нэгж	Төлбөрийн хэмжээ (төгрөг)	Жилд төлөх төлбөрийн хэмжээ(төгрөг)
1	Сумын төвийн айл өрх	Сар бүр	3,000	36,000
2	Хөдөөгийн айл өрх	Сар бүр	500	6,000
3	Эмийн сан	Сар бүр	5,000	60,000
4	Зочид буудал	Сар бүр	10,000	120,000
5	Төсөвт байгууллага	Сар бүр	5000	60,000
6	Хоолны газар, гуанз, ресторан	Сар бүр	3000	36,000
7	Хүнс, Барааны дэлгүүр	Сар бүр	5,000	60,000
8	Авто засвар, дугуй засварын газар	Сар бүр	3000	36,000
9	Уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ААН	Сар бүр	60,000	Үйл ажиллагаа явуулсан сараар
10	Авто зам Барилга угсралтын үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж	Сар бүр	60,000	Үйл ажиллагаа явуулсан сараар
11	Аялал жуулчлал зочлох үйлчилгээний үйл ажиллагаа явуулж байгаа ААН, хувь хүн	Сар бүр	20,000	Үйл ажиллагаа явуулсан сараар

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд
2026 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 7578 дугаарт бүртгэв.

БУЛГАН АЙМГИЙН ХУТАГ-ӨНДӨР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2026 оны 3 дугаар
сарын 31-ний өдөр

Дугаар 12

Хутаг-Өндөр
сум

БЭЛЧЭЭР АШИГЛАЛТЫГ ХАРИУЦЛАГАЖУУЛАХ ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.14 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.6 дахь хэсэг, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийн саналыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын XII дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1."Хутаг-Өндөр сумын бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журам"-ыг хавсралтаар баталсугай.

2.Уг тогтоолыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, бүртгүүлж ажиллахыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Ч.Отгонсайхан)-д даалгасугай.

3.Энэхүү журмыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэлд нийтэлсний дараа хүчин төгөлдөр мөрдсүгэй.

4.Журмыг мөрдөж эхэлсэн өдрөөс сумын малчид, мал бүхий иргэд, хуулийн этгээдэд сурталчлан, удирдлага зохион байгуулалтаар ханган хэрэгжүүлж ажиллахыг сумын Засаг дарга (Ж.Ууганбаяр)-т даалгасугай.

5.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ногоон хөгжил, байгаль орчин, аялал жуулчлал, Хөдөө аж ахуйн хөгжлийн асуудал эрхэлсэн хороонд үүрэг болгосугай.

ДАРГА

Б.БААСАНЦЭРЭН

*Хутаг-Өндөр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны 3
дугаар сарын 31-ний өдрийн 12 дугаар тогтоолын хавсралт*

**БУЛГАН АЙМГИЙН ХУТАГ-ӨНДӨР СУМЫН БЭЛЧЭЭР
АШИГЛАЛТЫГ ХАРИУЦЛАГАЖУУЛАХ ЖУРАМ**

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмын зорилго нь бэлчээр ашиглалтыг бэлчээрийн нөөц, даац болон экологийн чадавхад нь тохируулан зохистой төлөвлөх, зохицуулах замаар бэлчээрийн ургамлын байгалийн жамаар сэргэн ургах боломжийг бүрдүүлэх, бэлчээр ашиглагчдыг хариуцлагажуулах, бэлчээрийн даацад тохирсон мал сүрэг өсгөн үржүүлэх, мал аж ахуйн үйлдвэрлэлийн тогтвортой байдлыг хангахад оршино.

1.2.Үүний хүрээнд сум, багийн хэмжээнд бэлчээрийн менежментийг тухайн нутгийн бэлчээрийн экологийн чадавх болон ашиглагчдад суурилсан нэгдсэн аргачлалаар төлөвлөх, улирлын болон богино хугацааны хуваарьт ашиглалтыг хэрэгжүүлэх, хамгаалах, нөхөн сэргээх, мөн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхтэй холбогдсон үйл ажиллагаа, харилцааг зохицуулна.

1.3.Энэхүү журмыг Хутаг-Өндөр сумын нутаг дэвсгэрт дагаж мөрдөнө.

1.4.Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журам, төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбогдох арга хэмжээнд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг сумын төсөв, төлөвлөгөөнд жил бүр тусгаж Төсвийн тухай хуулийн 58.2, 60.2.8-д заасны дагуу санхүүжүүлнэ.

1.5.Газрын тухай хуулийн 50.1.1-т заасны дагуу бэлчээрийн төлөв байдал, чанарыг хадгалах, байгалийн аясаар болон хүний үйл ажиллагааны улмаас хөрсний үржил шим буурах, бэлчээрийн ургамлын бүрхэвч талхлагдах, хөрс элэгдэх, эвдрэх, хуурайших, намагжих, давсжих, бохирдох, хордохоос сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын тодорхой хувийг бэлчээр ашиглагч хариуцна.

1.6.Сумын нутаг дэвсгэрт Монгол Улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Газрын тухай хууль, Зөрчлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжуудын хэрэгжилтийг хангахад бэлчээр, ус ашиглагч малчид, малчдын бүлэг, хэсэг, анхдагч холбоо, аж ахуйн нэгж, байгууллагууд энэхүү журмыг мөрдлөг болгон ажиллана.

ХОЁР. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

2.1.Зуслан, намаржаа, өвөлжөө, хаваржааны бэлчээр, отрын бүс нутгийг Газрын тухай хуулийн 52.2-д зааснаар тогтооно.

2.2.Тухайн жилд бэлчээр чөлөөлсөн бүс нутагт мал оруулан гишгүүлэх, заасан хугацаанаас түрүүлж зөвшөөрөлгүйгээр бүс нутагт буудаллахгүй байх.

2.3.Сумын иргэдэд бэлчээр ашиглаж байсан уламжлалт туршлагыг түгээн дэлгэрүүлэх.

2.4.Нутаглаж байгаа газрынхаа гол ус, байгаль орчныг бохирдуулахгүй байх зэрэг үйл ажиллагааг иргэн бүр өөрийн санаачилгаар хийдэг байх, энэ ажлыг үр хүүхдүүд, залуу хойч үедээ өвлүүлэх.

2.5.Иргэдийн шинээр эзэмших өвөлжөө, хаваржааны хоорондын зайг зөвшилцсөнөөс бусад тохиолдолд нь 500 метрээс дээш зайд зайд байрлах.

2.6.Сумын хилийн зааг доторх нутаг бэлчээрийг зүй зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, сайжруулах.

ГУРАВ. Бэлчээр ашиглалтыг төлөвлөх

3.1.Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө нь сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсэг байна.

3.2.Бэлчээр ашиглалтыг төлөвлөлт, хэрэгжүүлэлт, үр дүнг хянах үнэлэх гэсэн үндсэн 3 түвшинд зохион байгуулна.

3.3.Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөнд бэлчээрийг улирлаар ашиглах, зун-намрын бэлчээрийг сар, улирал, богино хугацаагаар сэлгэх, ашиглах, өнжөөх хуваарь, отор нүүдэл хийх, бэлчээрийн усан хангамжийг сайжруулах, хадлангийн талбайг сайжруулах, бүтээмжийг нэмэгдүүлэх, бэлчээрийн хортон мэрэгчидтэй тэмцэх, доройтсон бэлчээрийг сэргээн сайжруулах зэрэг бэлчээрийн менежментийн арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаа, хариуцах талууд, шаардлагатай төсвийг эх үүсвэрийн хамт тусгана.

3.4.Бэлчээр ашиглалтыг төлөвлөхдөө дараах зарчмыг баримтална:

3.4.1.Бэлчээрийн төлөв байдал, экологийн чадавх, сүүлийн 3-аас доошгүй жилийн дунджаар тооцсон даац багтаамжид суурилах,

3.4.2.Бэлчээр ашиглагчдын тэгш оролцоог хангах.

3.5.Тухайн жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөө (цаашид “бэлчээр ашиглалтын төлөвлөгөө” гэх) нь дараах шаардлагыг хангасан байна.

3.5.1.Бэлчээр ашиглалтын нөлөөг хянах фото мониторингийн үр дүн болон бэлчээрийн төлөв байдал, чанарын хянан баталгаа, нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө дээр үндэслэсэн байх,

3.5.2.Бэлчээрийн тухайн жилийн нөөц, даацад тохируулан бэлчээр сэлгэх, өнжөөх, хуваарьтай ашиглах арга хэмжээг хэрэгжүүлэх бэлчээр нутаг, үргэлжлэх хугацааг тодорхойлж зурагласан байх,

3.5.3.Бэлчээрийг ашиглалтаас чөлөөлж хамгаалах арга хэмжээг бэлчээрийн ургамлын өсөлт хөгжлийн үе шат болон байгалийн жамаар сэргэн ургах чадавхтай уялдуулсан байх,

3.5.4.Бэлчээрийн ургац сайтай хэсгээс хадлан бэлтгэх, мониторингийн байнгын цэг байгуулснаар мониторингийн дүн мэдээнд үндэслэж хадлангийн талбайг тордож сайжруулах, хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх,

3.5.5.Бэлчээр дэх уст цэг, хужир мараа бүхий газрыг тодорхой хуваарь, нөхцөл болзлын дагуу нийтээр ашиглах нөхцөлийг бүрдүүлсэн байх,

3.5.6.Сумын Засаг даргын Тамгын газрын Хөдөө аж ахуйн тасаг, газрын даамал, цаг уурын ажилтан нар хамтран тухайн жилийн бэлчээрийн даацад үндэслэн баг тус бүрийн болон бэлчээр ашиглагч малчид, малчин өрхийн анхдагч холбооны бэлчээр нутагт өвөлжих, хаваржих малын тоог тооцож жил бүрийн 9 дүгээр сарын 15-ны өдрийн дотор багийн Засаг даргад хүргүүлнэ.

3.5.7.Багийн Засаг дарга нар тус багийн иргэдийн Нийтийн Хурлаар энэ журмын 3.5.6-д заасан малын тоо, бэлчээр ашиглагч малчид, малчин өрхийн анхдагч холбооны саналд тулгуурлан дараа жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг жил бүрийн 4-р улирлын багийн хурлаар хэлэлцүүлж сумын Засаг даргад хүргүүлнэ.

3.5.8.Газрын тухай хуулийн 52.1-д заасны дагуу сумын Засаг даргын Тамгын газрын Хөдөө аж ахуйн тасаг, газрын даамал нь баг бүрийн иргэдийн Нийтийн Хурлаар дэмжигдсэн бэлчээр ашиглалт, хамгаалалтын төлөвлөгөөний саналыг нэгтгэж сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө (цаашид СГЗБТЖТ гэх)-нд тусган жил бүрийн 12 дугаар сард багтаан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулна.

3.5.9.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлагдсан СГЗБТЖТ-г тухайн ондоо багтааж аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газарт тус тус хүргүүлж, Засаг даргын Тамгын газрын веб сайтад байршуулна.

3.5.10.Тухайн сумын нутаг дэвсгэрт газар эзэмшигч, ашиглагч нь бэлчээр ашиглалтын жилийн төлөвлөгөө, хуваарийг боловсруулах, түүнийг хэрэгжүүлэхэд баг, сумын Засаг даргатай хамтран ажиллана.

ДӨРӨВ. Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах

4.1.Бэлчээр ашиглалтыг тухайн сум, багийн бэлчээрийн экологийн чадавх, бэлчээрийн төлөв байдлын өөрчлөлт болон мониторингийн тухайн жилийн дүн мэдээлэлд үндэслэн улирлаар, сараар, тодорхой хоног хугацаагаар төлөвлөж хэрэгжүүлнэ.

4.2.Өвөлжөө, хаваржааны бэлчээрийг сумын Засаг даргатай байгуулсан бэлчээр ашиглалтын гэрээнд тусгагдсан талуудын хүлээх үүргийн дагуу ашиглах ерөнхий зохицуулалтыг баримтална.

4.3.Зуслан-намаржааны бэлчээрийг СГЗБТЖТ-ний дагуу малчин ерхийн анхдагч холбоо малчид, мал бүхий иргэд зохистой ашиглана.

4.4.Бэлчээр ашиглагчдад гэрээгээр ашиглуулж байгаа болон уламжлалт зохицуулалтаар ашиглаж байгаа бэлчээрт мал дайран өнгөрөх, тууварлах, түр буудаллах хугацааг 1-3 хоногоос илүүгүйгээр тогтооно.

4.5.Бэлчээрийн газрыг урт богино хугацаагаар чөлөөлөх, малын тоо, сүргийн бүтцийг бэлчээрийн нөөц, зах зээлийн эрэлтэд нийцүүлэх зорилгын хүрээнд гаднаас мал оруулах, оторлуулах талаар баримталж буй бодлого, арга хэмжээний талаар хөрш зэргэлдээ сумдад албан ёсоор мэдэгдэж хамтран ажиллана.

4.6.Шилжин ирэхээр хүсэлтээ гаргасан мал бүхий болон малчин ерхийг “Монгол Улсын нутаг дэвсгэрт шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журам”-ын 2.1-т заасны дагуу тухайн багийн иргэдийн Нийтийн Хурлаар оруулж, шилжиж ирсэн тохиолдолд багийн иргэдийн Нийтийн Хурлаас өвөлжөө, хаваржааны нутгийг зааж өгөх ба жилийн дөрвөн улиралд нутаглаж сум, багаас баталсан журмыг дагаж мөрдөх үүрэг хүлээнэ.

4.7.Сумын отрын нөөц бэлчээрт орох, гарах хугацаа болон дамжин өнгөрөх маршрутыг сумын Засаг даргын захирамжаар тогтооно.

4.8.Отрын нөөц бэлчээрт орох малд тухайн сумын Мал эмнэлгийн тасаг малын эрүүл мэндийн тодорхойлолт гаргах, мал эмнэлгийн үйлчилгээнд хамруулах арга хэмжээг зохион байгуулна.

4.9.Зун-намрын бог мал оторлолтыг 7 дугаар сарын 20-оос хожимдуулалгүй эхлүүлэх, адууг өвлийн оторт 12 дугаар сарын дундаас оройтуулалгүй гаргах, бог мал төллөсний дараа буюу 4 дүгээр сарын 01-ний дотор отроос буух ажлыг зохион байгуулна.

4.10.Аливаа бэлчээрийн ашиглалтын горим ачааллыг тухайн экосистемийн хэвийн үйл ажиллагаа, экосистем дэх байгалийн баялаг, зэрлэг ан амьтад, тэдгээрийн амьдрах орчин нөхцөлийг цогцоор нь хангах түвшинд тохируулна.

4.11.Бэлчээрийн доройтлыг бууруулах, доройтсон бэлчээрийг сэргээн сайжруулахын тулд сум хоорондын хилийн цэс, орон нутгийн зам болон малын хөлөөс чөлөөлсөн бэлчээрийг тэмдэгжүүлэх, шинэ зам гаргахгүй байх, чөлөөлсөн бэлчээрт мал оруулахгүй байх анхааруулга тэмдгийг тавих ажлыг сум, багийн Засаг дарга нар хариуцан хэрэгжүүлнэ.

4.12.Шинээр өрх тусгаарласан малчин өрхөд өвөлжөө, хаваржаа барих газрын асуудлыг иргэний хүсэлт, өргөдлийг тухайн багийн иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцэж, гаргасан саналыг сумын газрын даамалд хүргүүлж, СГЗБТЖТ-д тусган батлуулсны үндсэн дээр сумын Засаг дарга зохицуулж шийдвэрлэнэ.

4.13.Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, бэлчээрийн менежментийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлын зардлыг сумын төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн (ОНХС) Малын тоо толгойн албан татвараас санхүүжүүлнэ.

4.14.Малын тоо толгойн албан татварын орлогын 10-аас доошгүй хувийг бэлчээрийн менежментийн үйл ажиллагааг сайжруулахад зарцуулна.

ТАВ. Бэлчээрийн төлөв байдал, ашиглалтын нөлөөг хянах,

5.1.Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилт болон бэлчээр ашиглалтын нөлөөг фото мониторингийн үр дүнгээр үнэлнэ.

5.2.Бэлчээрийн төлөв байдал, бэлчээр ашиглалтын нөлөөг үнэлж, ургац тогтоохдоо бэлчээр ашиглагчид болон улирлын бэлчээрийг төлөөлөхүйц мониторингийн цэгүүдийг хамруулж үндэсний түвшний нэгдсэн арга аргачлалыг баримтална .

5.3.Фото мониторингийн анхдагч мэдээлэл болох зурган мэдээлэлд боловсруулалт хийж, бэлчээрийн ургамлыг аж ахуйн бүлгээр ангилан эзлэх хувь хэмжээн дээр тулгуурлан тухайн бэлчээрийн төлөв байдлыг тодорхойлохын зэрэгцээ “Монгол орны бэлчээрийн төлөв байдлын өөрчлөлтийн загвар” каталогийг ашиглан сэргэх чадавхыг тодорхойлно.

5.4.Фото мониторингийн хүрээнд Газрын даамал, ХААТ-ийн мэргэжилтэн, цаг уурын ажилтан нар хамтран бэлчээрийн даац, ачааллыг ХХААХҮ-ийн сайд, БОАЖ-ын сайд болон Үндэсний статистикийн хорооны даргын 2019 оны 8 сарын 5-ны өдрийн тушаалаар батлагдсан “Малын бэлчээрийн даац тооцох нэгдсэн аргачлалаар тооцно,

5.5.Малын тоог даацад тохируулах сүргийн эргэлтийн урт богино хугацааны төлөвлөлтийг бэлчээрийн сүүлийн 3 жилийн даац багтаамжийн дунджаар тооцно.

5.6.Фото мониторингийн байнгын цэгүүдээс гадна тодорхой зорилгоор цэг шинээр нэмж байгуулах, мөн хасах боломжтой.

ЗУРГАА.Бэлчээр ашиглагчдын эрх, үүрэг

6.1.Малчин, мал бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч нь бэлчээр ашиглалтын талаар дараах нийтлэг эрх, үүрэгтэй:

6.1.1.Бэлчээр, байгаль орчин, усны эх үүсвэрийг хог хаягдал,

хортой бодис, малын бууц, шавхай, сэгзэм зэрэг зүйлээр бохирдуулахгүй байх, бохирдол үүссэн тохиолдолд тухай бүр цэвэрлэх.

6.1.2.Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан хуваарийн дагуу зун, намрын бэлчээрийн газрыг Хутаг-Өндөр сумын малчид, мал бүхий иргэд нийтээрээ зохион байгуулалттай ашиглах

6.1.3.Сум, багийн иргэдийн хурал, өдөрлөг, бэлчээрийн менежментийн төлөвлөгөө боловсруулах болон бусад холбогдох арга хэмжээнд идэвхтэй оролцох.

6.1.4.Бэлчээрийг өнжөөх, чөлөөлөх, сэлгэх, отор нүүдэл хийх талаар гарсан шийдвэрийг дагаж мөрдөж биелүүлэх.

6.1.5.Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө, хуваарьт тусгагдсан, нэгдсэн зохицуулалтаар малаас чөлөөлсөн болон тэмдэг, тэмдэглэгээ бүхий бэлчээрт дур мэдэн нутаглахгүй, мал оруулахгүй байх, малаа хариулгатай байлгах, мөн өвөлжөө, хаваржааг холбогдох зөвшөөрөлгүйгээр шинээр барихгүй байх.

6.1.6.Бэлчээрийн хуваарийн дагуу газраа чөлөөлөөгүйгээс албадан нүүлгэсэн тохиолдолд гарсан зардлыг тухайн этгээд өөрөө хариуцах.

6.1.7.Өөрийн ашиглаж байгаа бэлчээрт ой, хээрийн түймэр болон байгаль орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох байгууллагад мэдээлж, хамтран ажиллах.

6.1.8.Эрчимжсэн суурин мал аж ахуй эрхлэх, тэжээвэр амьтан өсгөн үржүүлэх, бэлчээр нөхөн сэргээх, мод тарих, гол, горхи, булаг шандын эх ундаргыг хамгаалах зэрэг зориулалтаас бусад тохиолдолд бэлчээрийг хашиж хамгаалахгүй байх.

6.1.9.Сумын Засаг дарга болон холбогдох байгууллагаас гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг хангаж, эрх бүхий байгууллагаас тавьсан шаардлагыг биелүүлэх.

6.1.10.Мал худалдаж авах, бэлгэнд авах, эсхүл өөр аймаг, сумаас отроор болон нүүдлээр ирсэн тохиолдолд сумын мал эмнэлгийн тасагт мэдэгдэж, урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах.

6.2.Малчин өрхийн анхдагч холбоо нь Газрын тухай хууль-ийн 52.2 дугаар зүйлийг үндэслэн сумын Засаг даргатай бэлчээр ашиглалтын гэрээ байгуулж болох бөгөөд холбогдох харилцааг уг гэрээгээр зохицуулна.

6.3.Эрчимжсэн суурин мал аж ахуй эрхлэх зориулалтаар хашсан бэлчээрийг Газрын тухай хууль-ийн 52.5 дугаар зүйлд заасны дагуу тодорхой болзол, нөхцөл бүхий гэрээний үндсэн дээр ашиглуулж болно.

6.4.Бэлчээрийн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор Орон нутгийн хөгжлийн сан

(ОНХС)-д төслийн санал хүргүүлэх, дэмжигдсэн төслийг хэрэгжүүлэхэд оролцох.

6.5.Бэлчээрийн менежментийн чиглэлээр улсын төсөв, ОНХС болон бусад санхүүжилтээр хэрэгжүүлж буй үйл ажиллагааны явц, хэрэгжилтэд хяналт тавих, хамтран ажиллах.

ДОЛОО.Бэлчээр ашиглалтын талаар сум, багийн нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага, тухайн шатны Засаг дарга, албан хаагчдын хэрэгжүүлэх үйл ажиллагаа.

7.1.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

7.1.1.Сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд бэлчээр ашиглалт, хамгаалалтын асуудлыг шаардлагатай төсвийн хамт тусгаж батлах, биелэлтийг хэлэлцэж чиглэл өгөх.

7.1.2.Энэхүү Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журмын төслийг хэлэлцэж батлах, хэрэгжилтэд хяналт тавих, өөрчлөх.

7.1.3.Байгаль орчин, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлыг харгалзан нутаг дэвсгэртээ бэлчээрийн болон суурин мал аж ахуй, зөгийн аж ахуй зэрэг бэлчээр ашиглагч бусад аж ахуйг хөгжүүлэхдээ бэлчээрийн экологийн чадавх, тохиромжтой болон хэрэгцээт байдлыг үндэслэн бүсчлэн тогтоох.

7.2.Багийн иргэдийн Нийтийн Хурал дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

7.2.1.4-р улирлын хурлаар жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөө, гэрээний хэрэгжилтийг хэлэлцэх.

7.2.2.Тухайн жилд хийж гүйцэтгэх бэлчээрийн менежментийн арга хэмжээний санал, шаардагдах зардлыг хэлэлцэж, сумын Засаг даргад уламжлах.

7.2.3.Бэлчээрийн даацад малын тоо, нягтралыг тохируулах боломжит хувилбарыг тодорхойлох болон бэлчээр ашиглалтын төлөвлөлтөд малчид, малчин өрхийн анхдагч холбооны төлөөллийг оролцуулах.

7.2.4.Бэлчээрийн менежментийн зардлын бүрдүүлэлт, зарцуулалтын байдалд хяналт тавих.

7.3.Сумын Засаг дарга дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

7.3.1.Газрын тухай хуулийн 52.2-т заасны дагуу тухайн жилийн бэлчээрийн гарц, иргэдийн саналыг харгалзан өвөлжөө, хаваржааны бэлчээрийг малаас чөлөөлөх, мал оруулах хугацааг тогтоох

7.3.2.Сумын бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах.

7.3.3.Багийн Засаг дарга, мэргэжилтнүүдийн ажлыг үнэлэхдээ тухайн жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөө болон Бэлчээр

ашиглалтыг хариуцлагажуулах журмын хэрэгжилтийг нэг үзүүлэлт болгох.

7.3.4.Энэ журмын хэрэгжилт, бэлчээр ашиглах гэрээний хүрээнд үлгэр жишээ ажиллаж буй баг, малчин өрхийн анхдагч холбоо, малчин, мал бүхий өрхөд санхүүгийн дэмжлэг үзүүлэх, шагнал урамшуулалд тодорхойлох.

7.3.5.Гол горхи, булаг шандын эх ундаргыг хамгаалах, эрчимжсэн суурин мал аж ахуй эрхлэх болон тэжээвэр амьтныг өсгөн үржүүлэхээс бусад тохиолдолд бэлчээр хашихыг хориглох.

7.3.6.Малчдад уламжлалт бэлчээр ашиглалт, доройтсон бэлчээрийг нөхөн сэргээх, сайжруулах чиглэлээр сургалт, мэдээлэл зохион байгуулж, бэлчээрийг зохистой ашиглах дадал, хандлагыг төлөвшүүлэх ажлыг хэрэгжүүлэх

7.3.7.Тухайн жилийн бэлчээрийн фото мониторингийн үнэлгээ, бэлчээрийн даац зэргийг үндэслэн бусад аймаг, сумын Засаг даргатай отор нүүдлийн гэрээ байгуулах эсэхээ шийдвэрлэж, гэрээнд хугацаа, бэлчээр нутгийг заавал тусгана.

7.3.8.Бэлчээрийн даацыг тодорхойлох, суурь судалгааны үндсэн цэгүүдийг хамгаалах, мониторингийн цэгийн тоог нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах.

7.3.9.Бэлчээрийн менежментийн ажлын хэсгийг байгуулах, ажлын хэсгийн удирдамжийг батлах, үйл ажиллагааны зардлыг шийдвэрлэх, нэгдсэн удирдлагаар хангах.

7.3.10.Нөөцөлсөн нутаг бэлчээрийг ашиглах зайлшгүй шаардлага гарсан үед сумын Засаг дарга шийдвэр гарган хэрэгжилтийг зохион байгуулна.

7.3.11.Малчин өрхийн анхдагч холбоо, айл өрх саахалтаараа хэлэлцэн тодорхой бэлчээр нутгийн менежментийг сайжруулан ашиглахыг дэмжиж уг бэлчээр нутгийг тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгах саналыг багийн Иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлж батлуулна.

7.3.12.Сумын нутагт ашиглагддаггүй алсын бэлчээрийг ашиглах зорилгоор уст цэг гарган тэлж ашиглаж байгаа малчин өрхийн анхдагч холбоо, иргэдийг бодлогоор дэмжин тухайн жилийн бэлчээрийн хуваарьт тусгаж ажиллахдаа зориулалтаасаа хамаарч “Усны тухай” хуулийн 27.1, 28.6-т заасан заалтыг мөрдлөгөө болгон ажиллана.

7.3.13.Цаг хүндэрсэн тохиолдолд сумын бэлчээрт өөр аймаг, сумын нутгаас отроор өвөлжих, хаваржих малыг оруулахдаа энэ журам болон багийн иргэдийн Нийтийн Хурлын шийдвэрийг танилцуулж, мал эмнэлгийн Тасгийн Улсын байцаагч, Сумын Цагдаагийн тасгийн хяналтын дор бүртгэл мэдээллийг шалгаж зөвшилцсөний үндсэн

дээр тухайн малчин өрхтэй гэрээ байгуулж, бэлчээр нутгийг зааж өгч нэвтрүүлэх.

7.3.14.Сумын нутаг дэвсгэрт дэх төв, суурин газарт мал оруулах, гаргах асуудлыг шийдвэрлэх.

7.4.Багийн Засаг дарга дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

7.4.1.Багийн тухайн жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөө, хуваарийг багийн иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлэх, санал авах, төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах.

7.4.2.Тухайн жилд хэрэгжүүлэх бэлчээр ашиглалтын төлөвлөгөө, шаардагдах зардлын төсөлд малчин өрх, малчин өрхийн анхдагч холбооны саналыг авч тусгах, сумын Засаг даргад уламжлан шийдвэрлүүлэх, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж тайлагнах.

7.4.3.Багийн иргэдийн Нийтийн Хурлаас гарсан санал, шийдвэр, бэлчээр ашиглалтын төлөвлөгөө, бэлчээр ашиглах хуваарийг малчин өрхүүдэд танилцуулах, хэрэгжилтийг зохион байгуулах.

7.4.4.Бусдын эзэмшил, ашиглалтад олгоогүй хадлангийн талбай болон бэлчээр, уст цэгийн хамгаалалт, ашиглалтын ажлыг зохион байгуулах.

7.4.5.Бэлчээр ашиглалтын хуваарийг зөрчсөн малчин, мал бүхий иргэнд хугацаатай мэдэгдэх хуудас өгч, сумын Засаг даргын шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

7.4.6.Бэлчээрээ чөлөөлөх хуваарийн дагуу газраа чөлөөлөөгүй малчин, мал бүхий иргэнийг албадан нүүлгэж, гарсан зардлыг тухайн малчнаас гаргуулах.

7.5.Сумын газрын даамал дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

7.5.1.Сумын нөөц бэлчээрийн хэмжээ, байршлыг газрын нэгдмэл сангийн бусад ангиллын газартай давхцуулахгүйгээр зураглан мэдээллийн санд оруулах.

7.5.2.Өвөлжөө, худаг, уст цэгийн байршлыг сумын газрын мэдээллийн санд оруулах, тогтмол шинэчлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих.

7.5.3.Сумын Засаг даргатай малчин өрхийн анхдагч холбооны байгуулсан бэлчээр ашиглуулах гэрээг бүртгэх, гэрээг улсын газрын мэдээллийн нэгдсэн санд оруулах ажилд хяналт тавих, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх.

7.5.4.Бэлчээр ашиглуулах гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилт, биелэлтийг дүгнэх чиглэлээр холбогдох албан тушаалтан, байгууллага, малчдыг мэдээллээр хангах.

7.5.5.Газрын тухай хуулийн 58.5 дахь хэсэгт заасны дагуу бэлчээр, хадлангийн газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг 5 жил тутамд мэргэжлийн байгууллагаар хийлгэх ажлыг зохион

байгуулах, хяналт тавих, дүнг мэдээлэх.

7.5.6.Фото мониторингийн аргачлалын дагуу буулгасан зурган мэдээлэлд боловсруулалт хийж, төлөв байдлыг тодорхойлох, даацын мэдээ гаргах.

7.5.7.Фото мониторингийн дүнг үндэслэн орон нутгийн удирдлага, малчин өрхийн анхдагч холбоо, малчдад зориулсан тайлан, мэдээ гаргах ажлыг сумын бэлчээрийн мэргэжилтэнтэй хамтран хариуцна.

7.5.8.Журмын хэрэгжилтэд хяналт тавьж Уг журмын 8.1, 8.2, 8.3, 8.4, 8.5, 8.6, 8.7 дэх заалтуудын баримтлан ажиллана.

7.6.Сумын цаг уурын мэргэжилтний дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

7.6.1.Тухайн жилийн сум, багийн нутагт өвөлжих хаваржих малын боломжит даац ачааллыг тооцох ажилд оролцох, холбогдох байгууллага, албан тушаалтан, малчдад мэдээлэх.

7.6.2.Хур тунадас бага үед үүлэнд болон цаг агаарт зориудаар нөлөөлөх экспедиц ажиллуулах мэргэжил арга зүйн удирдлагаар хангах ажлыг зохион байгуулна.

7.6.3.Ган, зуд, үерийн эрсдэлийн үнэлгээ хийх ажилд оролцож ажиллана.

7.7.Мал эмнэлгийн тасаг дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

7.7.1.Мал, амьтны шилжилт хөдөлгөөн, мал, амьтны гаралтай хүнсний болон хүнсний бус түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, аюулгүй байдлын баталгаажуулалтын хяналтыг тогтмол хэрэгжүүлнэ.

7.7.2.Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хариуцсан нутаг дэвсгэр дэх мал, амьтны шилжилт хөдөлгөөний бүртгэл хөтлөлтийг малчин өрхийн малын албан ёсны бүртгэл, мал эмнэлгийн гэрчилгээ /эрүүл мэндийн тодорхойлолт/ олголттой харьцуулан хяналт тавих.

7.7.3.Малын гоц халдварт өвчний эрсдлээс сэргийлэхийн тулд Хутаг-Өндөр сумын нутаг дэвсгэрээр дайран өнгөрч буй малыг, Мал эмнэлэгийн Гэрчилгээ болон Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагчийн хяналт зөвшөөрөлгүйгээр Хутаг-Өндөр сумын нутаг дэвсгэрээр мал нэвтрэхийг хориглох.

7.7.4.Журмын хэрэгжилтэд хяналт тавьж Уг журмыг баримтлан ажиллана

7.7.5.Малын эрүүл мэндийг сайжруулах, устай холбоотой өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор малын суурин болон зөөврийн ванн барих, ашиглах тохиолдолд “усны тухай хуулийн 22.2.1, 22.6-т заасан заалтын хүрээнд усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийн гадна байршуулах болон 24.1-т заасан заалтуудыг мөрдлөг

болгон ажиллана.

7.8.Байгаль орчны хяналтын улсын байцаагч дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

7.8.1.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Засаг даргын захирамжаар бэлчээр, хадлангийн чиглэлээр гаргасан тогтоол, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавина.

7.8.2.Монгол Улсын Зөрчлийн тухай хуулийн 7.7.2, 8.1.6 дахь заалт болон холбогдох хуулийн дагуу зөрчил арилгуулахаар газрын даамалд Сумын Байгаль орчны хяналтын Улсын байцаагч хүсэлт гаргаж ажиллах.

7.8.3.Журмын хэрэгжилтэд хяналт тавьж Уг журмын 8.1, 8.2, 8.3, 8.4, 8.5, 8.6, 8.7 дэх заалтуудын баримтлан ажиллана.

7.9.Сумын Хөдөө аж ахуйн тасаг дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

7.9.1.Малчдад бэлчээр ашиглалтын ач холбогдлыг ойлгуулж, мэдлэг олгох, доройтсон бэлчээрийг нөхөн сэргээх сайжруулах талаар сургалт зохион байгуулах бэлчээрийг зөв зохистой ашиглах дадалтай болгох

7.9.2.Бэлчээрийн төлөв байдал, чанарт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэх, бэлчээр ашиглах, сэлгэх, өнжөөх хуваарийг боловсруулах

7.9.3.Бэлчээрийг хамгаалах, байгалийн жамаараа нөхөн сэргэх боломжийг бүрдүүлэх, бэлчээр дэх уст цэг, хужир мараа бүхий газрыг нийтээр ашиглах нөхцөлийг бүрдүүлэх ажлыг хэрэгжүүлэх

7.9.4.Нөөц нутаг бэлчээрийг ашиглах зайлшгүй шаардлага гарсан үед санал боловсруулж сумын Засаг даргад танилцуулах

7.9.5.Бэлчээрийн хөнөөлт мэрэгчид хортон шавжтай тэмцэх ажлыг малчдын оролцоотой зохион байгуулах

7.9.6.Малын тоог бэлчээрийн даацад нийцүүлэхэд чиглэсэн сүргийн зохистой бүтэц, харьцаа, сүргийн эргэлтийг оновчтой зохион байгуулах, бэлчээрийн даац, төлөв байдлын үнэлгээнд тулгуурлан малын тоо, төрөл сүргийн бүтцийг тохируулах ажлыг зохион байгуулах

НАЙМ. Журмын хэрэгжилтэд хяналт тавих, хариуцлага тооцох, хохирол нөхөн төлүүлэх.

8.1.Энэхүү журам нь Хутаг-Өндөр суманд малаа адгуулж буй иргэн, аж ахуй бүрт хамаарна.

8.2.Бэлчээр ашиглах асуудлаар гарсан аливаа маргааныг маргалдагч талууд болон болон багийн иргэдийн Нийтийн Хурлын дарга, багийн хурлын зөвлөл, багийн Засаг дарга нар, малчин өрхийн анхдагч холбооны дарга, төлөөллийг байлцуулан зөвшилцөж, журмын хүрээнд эвлэрлийн замаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ.

8.3.Маргалдагч талууд эс тохиролцсон тохиолдолд сумын Засаг дарга хуулиар олгогдсон эрх, үүргийн дагуу маргааныг шийдвэрлэнэ.

8.4.Бэлчээрт учирсан хохирлын экологи, эдийн засгийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар тогтоолгож, буруутай этгээдээр нөхөн төлүүлэх асуудлыг холбогдох хууль, журмын хүрээнд шийдвэрлүүлнэ.

8.5.Энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд Зөрчлийн тухай болон бусад хуулийн холбогдох зүйл, заалтыг үндэслэн хариуцлага хүлээлгэнэ.

8.6.Журмыг зөрчсөн албан тушаалтанд Төрийн албаны тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцно.

8.7.Харьяалалгүй мал, мал бүхий иргэнийг Хутаг-Өндөр сумын нутаг дэвсгэрт оруулж ирсэн, малыг нь өөрийн өвөлжөө, хаваржааны ойролцоо байрлуулсан тохиолдолд нь халдварт өвчлөл гаргах эрсдэлтэй тул тухайн малыг сумын нутаг дэвсгэрээс гаргахыг шаардана.

ЕС. ЖУРАМ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ.

9.1.Энэхүү журмыг Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэгт заасны дагуу захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэлд нийтэлсний дараа хүчин төгөлдөр дагаж мөрдүүлнэ.

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
БАЯН-ӨНДӨР СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2026 оны 3 дугаар
сарын 27-ны өдөр

Дугаар 08/01

Баян-Өндөр
сум

**ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖ ШИНЭЧЛЭН
ТОГТООХ ТУХАЙ**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь заалт, 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2 дахь заалт, Сангийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 192, А/243 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг тооцох аргачлал”-ыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Баян-Өндөр сумын хэмжээнд мөрдөгдөх хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг шинэчлэн хавсралтаар баталсугай.

2.Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг батлагдсан тарифын дагуу аж ахуйн нэгж, байгууллага, үйлдвэрлэл, үйлчилгээний газрууд, айл өрхүүдэд дагаж мөрдүүлэн, хэрэгжүүлж ажиллахыг сумын Засаг дарга (С.Чулууншагай)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 08/06 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

С.БАЯНЖАРГАЛ

*Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2026 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн
08/01 дүгээр тогтоолын хавсралт*

**СУМЫН ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖЫН
ХЭМЖЭЭ ТОГТООСОН ЖАГСААЛТ**

д/д	Үйлчилгээний төрлүүд	1 сарын төлбөр /төгрөг/	
1	Орон сууц гэр хорооллын айл өрх	1500	
2	Хөдөөгийн айл өрхүүд	833	
3	Худалдаа үйлчилгээний газрууд	Дэлгүүр	10,000
4		Шатахуун түгээх станц	10,000
5		Дугуй засвар	5000
6		Цайны газар	5000
7	Төрийн болон төрийн бус хувийн хэвшлийн байгууллагуудын хог хаягдал	Ерөнхий боловсролын сургууль	46080
8		Эрүүл мэндийн төв	5000
9		Сургуулийн өмнөх боловсролын байгууллага	5000
10		Соёлын төв	5000
11		Мал эмнэлэг	5000
12		Эргэлтийн эмийн сан	5000
13		Уурын зуух	100000
14	Малын гаралтай түүхий эд авдаг газар	40000	

Тайлбар:

1.Орон сууц гэр хорооллын өрх нь дунджаар 3 ам бүлтэй гэж тооцоход нэг хүнд 500 төгрөгийн хог хаягдлын хураамж ногдоно гэж тооцсон.

2.Хөдөөгийн айл өрх нь дунджаар 3 ам бүлтэй гэж тооцоход нэг хүнд 278 төгрөгийн хог хаягдлын хураамж ногдоно гэж тооцлоо.

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 3 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар А/164

Есөнбулаг
сум

ЦАГИЙН ХЯЗГААРЫГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.2, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэг, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.10 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй худалдаа, үйлчилгээний газрын үйл ажиллагаа явуулах цагийн хязгаарыг хавсралтаар шинэчлэн тогтоосугай.

2.Тогтоосон цагийн хязгаарыг мөрдүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Д.Бүрэнбаатар), сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийг холбогдох хууль, журмын дагуу захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс (Н.Эрдэнэ-Очир), Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтэс (Д.Чинзориг)-т тус тус даалгасугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн «Цагийн хязгаарыг шинэчлэн тогтоох тухай» А/199 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ЧИНБАТ

*Аймгийн засаг даргын 2026 оны
3 дугаар сарын 25-ны өдрийн
А/164 дүгээр захирамжийн хавсралт*

**СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ТҮҮГЭЭР ҮЙЛЧИЛГЭЭ
ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ ЦАГИЙН ХЯЗГААР**

Д/д	Тусгай зөвшөөрлийн төрөл	Цагийн хязгаар
1.	Согтууруулах ундаа худалдах	06:00-00:00
2.	Согтууруулах ундаагаар үйлчлэх	11:00-22:00
3.		14:00-01:00

БАЯНХОНГОР АЙМГИЙН БУУЦАГААН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2026 оны 3 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 07/47

Буянт

БЭЛЧЭЭР АШИГЛАЛТЫГ ХАРИУЦЛАГАЖУУЛАХ ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэр нэгж, түүний удирдлагын тухай тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.23, 35 дугаар зүйлийн 35.1.13, 35.1.14, 48 дугаар зүйлийн 48.1, Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 64 дүгээр зүйлийн 64.6, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.6, 52 дугаар зүйлийн 52.6, Монгол Улсын Хууль зүй дотоод хэргийн сайдын 2026 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 1/620 дүгнэлт, Баянхонгор аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 6/25 дугаар тогтоолыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2026 оны ээлжит VII дугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Бууцагаан сумын “Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Журмын хэрэгжилтийг хангах ажлыг хариуцан үр дүнтэй зохион байгуулж жил бүр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнан ажиллахыг сумын Засаг дарга (Х.Дагвадорж)-д үүрэг болгосугай.

3.Батлагдсан “Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журам”-ыг Захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлж мөрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, үйлчилгээ, дэд бүтэц хөгжлийн бодлогын хороонд даалгасугай.

4.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн ээлжит 6 дугаар хуралдааны “Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журам” баталсан 06/35 дугаар тогтоолыг хүчингүй болгосугай.

ДАРГА

Ш.ТҮВШИН

*Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны
3 дугаар сарын 30-ны өдрийн 07 дугаар
хуралдааны 07/47 тогтоолын 01 хавсралт*

**БАЯНХОНГОР АЙМГИЙН БУУЦАГААН СУМЫН БЭЛЧЭЭР
АШИГЛАЛТЫГ ХАРИУЦЛАГАЖУУЛАХ ЖУРАМ**

Нэг.Нийтлэг үндэслэл

Баянхонгор аймгийн Бууцагаан сумын нутаг дэвсгэрт бэлчээрийг ашиглах хамгаалах, нөхөн сэргээхтэй холбогдон үүсэх харилцааг энэ журмаар зохицуулна.

1.1.Энэхүү журмын зорилго нь бэлчээр ашиглалтыг тухайн орон нутгийн бэлчээрийн экологийн чадавхид суурилсан аргачлалаар төлөвлөх, бэлчээрийг түүний нөөц, даацад нь тохируулан байгалийн жамаараа нөхөн сэргэх боломжийг бүрдүүлсэн төлөвлөгөөний дагуу улирлыг хуваарьтайгаар зүй зохистой ашиглах, хамгаалахтай холбогдон нутгийн удирдлага, бэлчээр ашиглагчдын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2.Энэ журам нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Төсвийн тухай, Газрын тухай, Газрын төлбөрийн тухай,Малын генетик нөөцийн тухай, Мал, амьтны эрүүл мэндийн тухай, Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай, Байгаль орчныг хамгаалах тухай, Малын тоо толгойн албан татварын тухай, Малчны тухай, Усны тухай, Малчин өрхийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай, Уламжлалт мал аж ахуйд тулгамдаж байгаа уур амьсгалын өөрчлөлтөөс шалтгаалсан сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль,Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, орон нутгийн хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичиг болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд үйлчилнэ.

1.3.Журмыг хэрэгжүүлснээр бэлчээр ашиглах, хамгаалахад төрийн байгууллага, бэлчээр ашиглагчид (малчин өрх, малчин өрхийн анхдагч холбоо,нөхөрлөл, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч)-ыг үйл ажиллагаа, үүрэг хариуцлагажуулах арга хэмжээг нэгдсэн зохицуулалтаар хангах, бэлчээрийн төлөв байдлыг сайжруулах, доройтол, талхагдлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлт, хүний үйл ажиллагааны улмаас бэлчээрийн экосистемд үзүүлэх сөрөг нөлөөллийг сааруулах, мал аж ахуйн салбарт учрах байгалийн эрсдэлийг даван туулах чадавх дээшилнэ.

1.4.Газрын тухай хуулийн 50.1.1-т заасны дагуу бэлчээрийн төлөв байдал чанарыг хадгалах, хөрсний үржил шим буурах, бэлчээрийн ургамлын бүрхэвч талхлагдаж хөрс элэгдэх, эвдрэх,

хуурайших, намагших, давсжих, бохирдохоос сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын тодорхой хувийг бэлчээр ашиглагч малчин хариуцна.

1.5.Энэ журмыг Бууцагаан сумын нутаг дэвсгэрт бэлчээр ашиглаж байгаа малчин өрх, малчны бүлэг, хоршоо, малчин өрхийн анхдагч холбоо дагаж мөрдөнө.

Хоёр. Бэлчээр ашиглалтыг төлөвлөх

2.1.Бэлчээр ашиглалтыг төлөвлөхдөө дараах зарчмыг баримтлана

2.1.1.Бэлчээрийн даац, экологийн чадавхид суурилах;

2.1.2.Бэлчээр ашиглагчдын тэгш оролцоог хангах;

2.2.Тухайн жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөө (цаашид “бэлчээр ашиглалтын төлөвлөгөө” гэх) нь дараахь шаардлагыг хангасан байна:

2.2.1.Бэлчээрийн төлөв байдал, чанарт хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ (цаашид “мониторинг” гэх)-ний дүнд үндэслэсэн байх;

2.2.2.Тухайн жилийн нөөц, даацад тохируулан бэлчээрийг улирлын хуваарьтай ашиглах, сэлгэх, өнжөөх хуваарийг гаргасан байх;

2.2.3.Бэлчээрийг хамгаалах, байгалийн жамаар нөхөн сэргэх боломжийг бүрдүүлсэн байх;

2.2.4.Тариалангийн талбайгаас 500-1000м гадагш байх;

2.2.5.Бэлчээр дэх уст цэг, хужир мараа бүхий газрыг тодорхой хуваарь, нөхцөл болзлын дагуу нийтээр ашиглах нөхцөлийг бүрдүүлсэн байх;

2.2.6.Сумын Засаг даргын Тамгын газрын Хөдөө аж ахуйн тасаг, газрын даамал,цаг уурын ажилтан нар хамтран тухайн жилийн бэлчээрийн даацад үндэслэн баг тус бүрийн болон бэлчээр ашиглагч малчид, малчдын бүлэг, хэсгийн бэлчээр нутагт өвөлжих, хаваржих малын тоог тооцож жил бүрийн 9 дүгээр сарын 15-ны өдрийн дотор багийн Засаг даргад хүргүүлнэ.

2.2.7.Багийн Засаг дарга нар тус багийн иргэдийн Нийтийн Хурлаар энэ журмын 2.2.6-д заасан малын тоо, бэлчээр ашиглагч малчдын бүлэг, хэсгийн саналд тулгуурлан дараа жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг жил бүрийн 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор хэлэлцүүлж сумын Засаг даргад хүргүүлнэ.

2.2.8.Газрын тухай хуулийн 52.1-д заасны дагуу сумын Засаг даргын Тамгын газрын Хөдөө аж ахуйн тасаг, газрын даамал нь баг бүрийн иргэдийн Нийтийн Хурлаар дэмжигдсэн бэлчээр ашиглалт, хамгаалалтын төлөвлөгөөний саналыг нэгтгэж сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө (цаашид СГЗБТЖТ гэх)-нд тусган жил бүрийн 12 дугаар сард багтаан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулна.

2.2.9.Сумын нутаг дэвсгэрт газар эзэмшигч, ашиглагч нь бэлчээр ашиглалтын жилийн төлөвлөгөө, хуваарийг боловсруулах, түүнийг хэрэгжүүлэхэд баг, сумын Засаг даргатай хамтран ажиллана.

2.2.10.Аймаг дундын отрын бэлчээрт өвөлждөг, хаварждаг өрхийн болон малын тоог сумын бэлчээрийн менежментийн ажлын хэсэг тооцож, бэлчээр ашиглалтын төлөвлөгөөнд тусгана.

ГУРАВ. Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө, хуваарийг хэрэгжүүлэх.

3.1.Бэлчээр ашиглалтыг тухайн аймаг, сум, багийн бэлчээрийн экологийн чадавх, бэлчээрийн төлөв байдлын өөрчлөлт болон мониторингийн тухайн жилийн дүн мэдээлэлд үндэслэн улирлаар, тодорхой хугацаагаар төлөвлөх зарчмаар зохицуулна.

3.2.Өвөлжөө, хаваржааны бэлчээрийг сумын Засаг даргатай байгуулсан бэлчээр ашиглах гэрээний үндсэн дээр талуудын хүлээх үүргийн дагуу ашиглах ерөнхий зохицуулалтыг баримтална.

3.3.Зуслан-намаржааны бэлчээрийг СГЗБТЖТ-ний дагуу өрх, хот айл, бүлэг хэсгээр зүй зохистой ашиглах, зөвшөөрөлгүйгээр мал оруулахыг хориглоно.

3.4.Бэлчээр ашиглагчдад гэрээгээр ашиглуулж байгаа болон уламжлалт зохицуулалтаар ашиглаж байгаа бэлчээрээр мал дайран өнгөрөх, тууварлах, түр буудаллах хугацааг тухайн сумын онцлогт тохируулан 2-7 хоногоос илүүгүйгээр тогтооно.

3.5.Сумын Засаг даргын захирамжаар тогтоосон өвөлжөө, хаваржааны бэлчээрийг зун намрын улиралд малын хөлөөс чөлөөлөх хугацааг дагаж мөрдөнө.

3.6.Улирлаар ашиглах бэлчээрээс нүүх, буух хугацааг газарзүйн онцлог ба цаг агаарын нөхцөлөөс хамааруулан баг тус бүр өөрчлөж болох бөгөөд энэ өөрчлөлт нь зөвхөн тухайн улирал, жилд мөрдөгдөнө.

3.7.Зуслан-намаржааны бэлчээрийг тариалангийн талбайн захаас 500 метрээс доошгүй зайд байрлахаар зохион байгуулалт хийж, бэлчээр ашиглалтыг зохицуулна.

3.8.Шилжин ирэхээр хүсэлтээ гаргасан мал бүхий малчин өрхийг “Монгол Улсын нутаг дэвсгэрт шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журам”-ын 2.1-г заасны дагуу тухайн багийн иргэдийн Нийтийн Хурлаар оруулж, шилжиж ирсэн тохиолдолд багийн иргэдийн Нийтийн Хурлаас өвөлжөө, хаваржааны нутгийг зааж өгөх ба жилийн дөрвөн улиралд нутаглаж сум, багаас баталсан журмыг дагаж мөрдөх үүрэг хүлээнэ.

3.9.Сум болон сум дундын отрын нөөц бэлчээрт орох, гарах буюу дамжин өнгөрөх маршрутыг сумын Засаг даргын захирамжаар тогтооно.

3.10.Отрын нөөц бэлчээрт орох малд тухайн сумын Мал эмнэлгийн тасаг малын эрүүл мэндийн тодорхойлолт гаргах, мал эмнэлгийн үйлчилгээнд хамруулах арга хэмжээг зохион байгуулна.

3.11.Тухайн бэлчээрт байгаа байгалийн баялаг, ан амьтдыг хамгаалах, амьдрах орчин нөхцөлийг хангаж ашиглана.

3.12.Бэлчээрийн доройтлыг бууруулахын тулд орон нутгийн зам болон малын хөлөөс чөлөөлсөн бэлчээрийг тэмдэгжүүлэх, шинэ зам гаргахгүй байх, чөлөөлсөн бэлчээрт мал оруулахгүй байх анхааруулга тавих ажлыг багийн Засаг дарга нар хариуцан хэрэгжүүлнэ.

3.13.Шинээр өрх тусгаарласан малчин өрхөд өвөлжөө, хаваржаа барих асуудлыг тухайн багийн иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцэж, гаргасан саналыг үндэслэн сумын Засаг дарга зохицуулж шийдвэрлэнэ.

3.14.Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, бэлчээрийн менежментийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлын зардлыг сумын төсөв, Малын тоо толгойн албан татвараас санхүүжүүлнэ.

ДӨРӨВ. Бэлчээрийн төлөв байдлыг хянах, даац тогтоох

4.1.Бэлчээрийн төлөвлөлт, төлөвлөгөөний хэрэгжилт болон бэлчээр ашиглалтын үр нөлөөг мониторингийн үр дүнгээр үнэлнэ.

4.2.Бэлчээрийн төлөв байдлыг үнэлж, ургац тогтоохдоо улирлын бэлчээрийг төлөөлөхүйц мониторингийн цэг дээр тогтсон аргачлалыг баримтлан гүйцэтгэнэ.

4.3.Мониторингийн цэгийг сонгохдоо бэлчээр ашиглагч малчдын бүлэг, хэсгийн улирлын бэлчээр болон бэлчээрийн нийтлэг хэв шинжийг төлөөлөх чадварыг нь харгалзан тогтоох ба энэ ажилд малчид, бүлэг, хэсгийн төлөөллийг оролцуулна.

4.4.Мониторингийн цэгийн байршлыг сумын Засаг даргын захирамжаар баталгаажуулж, сумын бэлчээр ашиглалтын зурагт нэг бүрчлэн тэмдэглэнэ.

4.5.Мониторингийн аргачлалын дагуу буулгасан зурган мэдээлэлд боловсруулалт хийж, төлөв байдлыг тодорхойлох, ургацын мэдээ гаргах, даац тооцох ажлыг сумын газрын даамал, Хөдөө аж ахуйн тасаг, цаг уурын ажилтан нар хариуцан гүйцэтгэнэ.

4.6.Суурь судалгааны цэгээс бусад мониторингийн цэгийг бэлчээрийн ашиглалтаас шалтгаалаад нэмж, хасаж болно.

4.7.Сумын Засаг даргын Хөдөө аж ахуйн тасаг, газрын даамал, цаг уурын ажилтан нь ургацын мэдээг үндэслэн бэлчээрийн даацыг сум, баг, малчдын бүлэг, хэсгийн түвшинд тооцно.

4.8.Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Ус, цаг уур, орчны шинжилгээний төв нь сумдын бэлчээрийн ургац, даацын мэдээг нэгтгэн холбогдох байгууллага, сумдыг мэдээллээр хангана.

4.9.Бэлчээрийн даацыг хонин толгойгоор тооцож илэрхийлнэ. Малын тоог хонин толгойд шилжүүлэхдээ Тэмээ-5, Адуу-7, Үхэр-6, Хонь-1, Ямаа-0.9 гэсэн итгэлцүүрээр тооцно.

4.10.Бэлчээрийн даац тооцохдоо Үндэсний стасистикийн хорооны дарга, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн А/133, А/250, А/422 дугаар хамтарсан тушаалын хавсралт “Малын бэлчээрийн даац тооцох нэгдсэн аргачлал”-ын дагуу тооцно.

ТАВ. Бэлчээр ашиглагчдын эрх үүрэг.

5.1.Малчин, мал бүхий этгээд, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж нь бэлчээр ашиглалтын талаар дараах нийтлэг эрх, үүрэгтэй.

5.1.1.Бэлчээрийн даацад тохирсон тооны малыг өсгөн үржүүлэх, нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэх;

5.1.2.Сүргийн эргэлтийн төлөвлөлттэй уялдуулан, бэлчээрийн даац багтаамжаас хэтэрсэн малыг эдийн засгийн эргэлтэд оруулдаг байх;

5.1.3.Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх ажилд биечлэн оролцож, бэлчээрийг өнжөөх, чөлөөлөх, сэлгэх, отор нүүдэл хийх талаар гаргасан Багийн иргэдийн нийтийн хурлын тогтоол, сум, багийн Засаг даргын шийдвэрийг дагаж биелүүлэх, мөрдөх;

5.1.4.Бэлчээр ашиглалтын төлөвлөгөө, хуваарьт тусгагдсанаас бусад бэлчээрт дур мэдэн нутаглахгүй байх, зөвшөөрөлгүйгээр өвөлжөө, хаваржааг шинээр барихгүй байх.

5.1.5.Бэлчээр, байгаль орчин, усны эх үүсвэрийг хог хаягдал, хортой зүйлс, малын шавхай бууц, сэг зэмээр бохирдуулахгүй байх, тухай бүр цэвэрлэх;

5.1.6.Эрчимжсэн суурин мал аж ахуй эрхлэх болон тэжээвэр амьтныг өсгөн үржүүлэх, нөхөн сэргээх, мод тарихаас бусад зорилгоор бэлчээрийг хашиж хамгаалахгүй байх;

5.2.Бэлчээр ашиглагч малчин, малчдын бүлэг, малчин өрхийн анхдагч холбоо, хэсгийн зохион байгуулалтад орсон малчид нь Газрын тухай хуулийн 52.2-ыг үндэслэн сумын Засаг даргатай бэлчээр ашиглалтын гэрээ байгуулж болно.

5.3.Эрчимжсэн суурин мал аж ахуйн эрхлэх зорилгоор хашсан бэлчээрийг Газрын тухай хуулийн 52.5-т заасны дагуу тодорхой болзол, гэрээний дагуу ашиглуулж болно.

5.4.Өвөлжөө-хаваржаа, зуслан-намаржааны бэлчээр, хашаа хороо, худаг уст цэгт өөр аймаг, сум, багийн малыг дур мэдэн оруулах, бусдад дамжуулан ашиглуулах, түрээслүүлэх, шилжүүлэх тохиолдолд

БИНХ-аар оруулж хэлэлцүүлэн, сумын Засаг даргаас зөвшөөрөл авна.

5.5. Малчин өрхийн нэгдсэн холбооны тухай хуулийн 10 зүйлийн 10.2 заасны дагуу Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.7-д заасан газарт тэжээлийн ургамал тариалаж болно.

5.6. Атаршсан газрыг дахин ашиглах зорилгоор малчин өрхийн анхдагч холбоо, хоршоо, нөхөрлөл, малчны бүлэг, малчин өрхийн хамтын хэрэгцээнд тэжээлийн ургамал тариалах, эрчимжсэн мал аж ахуйд ашиглах таримал бэлчээр бий болгох зориулалтаар ашиглаж болно.

5.7. Худаг, уст цэгийн ашиглалтын зориулалтыг өөрчлөх, зөвшөөрөлгүй цооног өрөмдөх, худаг гаргах, суваг шуудуу татахыг хориглоно.

ЗУРГАА. Бэлчээр ашиглалтын талаар сум, багийн нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны болон тухайн шатны Засаг даргын хэрэгжүүлэх арга хэмжээ.

6.1. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

6.1.1. Сумын газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд бэлчээр ашиглалт, хамгаалалтын асуудлыг тусгаж батлах, биелэлтийг хэлэлцэж чиглэл өгөх;.

6.1.2. Сумын “Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журам”-ын төслийг хэлэлцэж батлах, хэрэгжилтэд хяналт тавих;

6.1.3. Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар баталсан журмыг Хууль зүй дотоод хэргийн яаманд бүртгүүлэх;

6.1.4. “Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журам”-ын хэрэгжилтийг хангаж ажиллахад шаардагдах төсвийг хуулийн хүрээнд хэлэлцэж батлах

6.1.5. “Бэлчээр ашиглалтыг хариуцлагажуулах журам”, бэлчээр ашиглуулах гэрээний хэрэгжилтийн тайланг хагас, бүтэн жилээр хэлэлцэж үнэлгээ, дүгнэлт, үүрэг чиглэл сумын Засаг даргад өгөх

6.2. Багийн иргэдийн Нийтийн Хурал дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

6.2.1. Жил бүрийн 10 дугаар сарын 15-ны дотор хуралдаж өмнөх жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөө, гэрээний хэрэгжилтийг хэлэлцэж үнэлгээ, дүгнэлт өгөх

6.2.2. Тухайн жилд хийж гүйцэтгэх бэлчээрийн менежментийн арга хэмжээний санал, шаардагдах зардлыг хэлэлцэж, сумын Засаг даргад уламжлах.

6.2.3. Бэлчээрийн даацыг тодорхойлох болон бэлчээр ашиглалтын төлөвлөлтөд малчид, малчдын бүлэг, хэсгийн төлөөллийг оролцуулах;

6.2.4.Бэлчээрийн менежментийн зардлын бүрдүүлэлт, зарцуулалтын байдалд хяналт тавих.

6.3.Сумын Засаг дарга дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

6.3.1.Газрын тухай хуулийн 52.2-т заасны дагуу тухайн жилийн бэлчээрийн гарц, иргэдийн саналыг харгалзан өвөлжөө, хаваржааны бэлчээрийг малаас чөлөөлөх, мал оруулах хугацааг тогтоох;

6.3.2.Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг энэхүү журамд нийцүүлэн боловсруулж, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хуралд өргөн мэдүүлж хэлэлцүүлэх, бэлчээр ашиглалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах.

6.3.3.Багийн Засаг даргын ажлыг үнэлэхдээ тухайн жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөө болон энэ журмын хэрэгжилтийг нэг үзүүлэлт болгох;

6.3.4.Энэ журмын хэрэгжилт, бэлчээр ашиглах гэрээний хүрээнд үлгэр жишээ ажиллаж буй баг, малчдын бүлэг, хэсэг, малчин, мал бүхий өрхийг давуу эрхээр санхүүгийн дэмжлэг үзүүлэх, шагнал урамшуулалд тодорхойлох;

6.3.5.Гол горхи, булаг шандны эх ундаргыг хамгаалах, эрчимжсэн суурин мал аж ахуй эрхлэх болон тэжээвэр амьтныг өсгөн үржүүлэх, доройтсон бэлчээрийг сайжруулахаас бусдаар бэлчээр хаших тохиолдолд сумын Засаг даргаас зөвшөөрөл авах.

6.3.6.Малчдад уламжлалт бэлчээр ашиглалт, доройтсон бэлчээрийг нөхөн сэргээх, сайжруулах талаар сургалт зохион байгуулах, бэлчээрийг зохистой ашиглах дадлыг бий болгох ажлыг зохион байгуулах;

6.3.7.Сумын бэлчээрийн даац хүрэлцээтэй жил өөр аймаг сумын нутгаас отроор мал оруулах, мөн бизнесийн чиглэлээр олноор худалдан авч бэлчээр ашиглаж байгаа иргэдийн малаас Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Хөдөө аж ахуйн газрын үнэлгээний тойргийн 1га бэлчээрийн газрын суурь үнэлгээ”-ний 0.03 хувиар нэг хонин толгойд ногдох бэлчээрийн газрын төлбөр авах;

6.3.8.Бэлчээрийн даацыг тодорхойлох, суурь судалгааны тогтоогдсон цэгүүдийг хамгаалах, мониторингийн цэгийн тоог нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах;

6.3.9.Бэлчээрийн менежментийн ажлын хэсгийг байгуулах, ажлын хэсгийн үйл ажиллагааны зардлыг шийдвэрлэх, нэгдсэн удирдлагаар хангах;

6.3.10.Сумын төв, суурин газарт мал оруулах, гаргах асуудлыг шийдвэрлэх.

6.3.11.Нийтээр ашиглах бэлчээрт зөвшөөрөлгүйгээр хашаа, саравч барьсан, бэлчээрийг хашсан тохиолдолд албадан буулгах ажлыг нэн даруй зохион байгуулах

6.3.12.Сумын нутаг дэвсгэрт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч этгээдийн дүйцүүлэн хамгаалах зардлыг бэлчээрт худаг гаргах, хөв цөөрөм байгуулах, хадлангийн талбай сайжруулах, хортон мэрэгчтэй тэмцэх арга хэмжээнд зарцуулах;

6.3.13.Газрын төлбөр, Малын тоо толгойн албан татвар, байгалийн нөөц ашигласны төлбөр, бэлчээр ашигласны төлбөрийн тодорхой хувийг холбогдох хуулийн дагуу бэлчээр ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд шаардагдах зардлыг зарцуулахаар сумын төсөвт тусгуулах, батлуулах

6.4.Багийн Засаг дарга дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

6.4.1.Багийн тухайн жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөө, хуваарийг багийн иргэдийн Нийтийн Хурлаар хэлэлцүүлэх, санал авах, төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах;

6.4.2.Сумын Засаг даргатай байгуулах гүйцэтгэлийн төлөвлөгөөнд энэхүү журмыг хэрэгжүүлэх арга хэмжээг тусгаж, хэрэгжүүлэх;

6.4.3.Тухайн жилд хэрэгжүүлэх бэлчээр ашиглалтын төлөвлөгөө, шаардагдах зардлын төсөлд малчин өрх, малчдын бүлэг, хэсгийн саналыг авч тусгах, сумын Засаг даргад уламжлан шийдвэрлүүлэх, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулж тайлагнах

6.4.4.Багийн иргэдийн Нийтийн Хурлаас гарсан санал, шийдвэр, бэлчээр ашиглалтын төлөвлөгөө, бэлчээр ашиглах хуваарийг малчин өрхүүдэд танилцуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;

6.4.5.Бусдын эзэмшил, ашиглалтад олгоогүй хадлангийн талбай болон бэлчээр, уст цэгийн хамгаалалт, ашиглалтын ажлыг зохион байгуулах;

ДОЛОО. Журмыг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагын үйл ажиллагаа.

7.1.Хөдөө аж ахуйн тасаг дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

7.1.1.Сум, багийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөө гаргах, журмын хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэл, үр дүнг тайлагнах;

7.1.2.Тухайн жилийн өвөл, хаврын бэлчээрийн даацыг аймгийн ус, цаг уур, орчны шинжилгээний газартай хамтран тогтоох, мал өвөлжүүлэх, хаваржуулах арга хэмжээг сумын хэмжээнд төлөвлөх, хэрэгжүүлэх, хэрэгжилтийг нэгтгэн дүгнэх, бэлчээрийн даац тодорхойлсон мэдээллийг малчдад хүргэх, холбогдох албан тушаалтнуудыг мэдээллээр хангах;

7.1.3.Бэлчээрийн даац, төлөв байдлын үнэлгээнд тулгуурлан малын тоо, төрөл, сүргийн бүтцийг тохируулах, мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээг мэргэжил, арга зүйн удирдамжаар хангах;

7.1.4.Бэлчээрийн ургамалд хөнөөл учруулж байгаа мэрэгч амьтан, шавжтай тэмцэх арга хэмжээг байгаль орчинд халгүй, дэвшилтэт арга технологи ашиглан бэлчээр ашиглагч малчин, тухайн багийн Засаг дарга нартай хамтран зохион байгуулах;

7.1.5.Багийн Иргэдийн Нийтийн Хурлын саналыг харгалзан бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх саналыг холбогдох байгууллагад уламжлуулах, шийдвэрлүүлэх;

7.1.6.Бэлчээр ашиглагч малчдад уламжлалт бэлчээр ашиглалт, доройтсон бэлчээрийг нөхөн сэргээх, хамгаалах талаар сургалт зохион байгуулах, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, бэлчээрийг зөв ашиглах дадлыг бий болгох ажлыг зохион байгуулах;

7.2.Газрын даамал дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

7.2.1.Жил бүр сумдад бэлчээрийн газарт фотомониторинг хийж, дүнг олон жилийн дундажтай харьцуулан аймаг, сумын удирдлагад мэдээллэх;

7.2.2.Бэлчээр ашиглагч малчдын бүлэг, хоршоо, малчин өрхийн анхдагч холбоо, баг, сумын тухайн жилд бэлчээрийн менежментийн чиглэлээр хийсэн ажлыг дүгнэх, дараа жилийн ажлыг төлөвлөхөд фотомониторингийн дүнг ашигладаг болох ажлыг зохион байгуулж хэвшүүлэх;

7.2.3.Сумын бэлчээрийн хэмжээ, байршлыг газрын нэгдмэл сангийн бусад ангиллын газартай давхацуулахгүйгээр зураглан мэдээллийн санд оруулах.

7.2.4.Өвөлжөө, худаг, уст цэгийн байршлыг сумын газрын мэдээллийн санд оруулах, тогтмол шинэчлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих;

7.2.5.Сумын Засаг даргатай малчин, малчдын бүлэг, хоршоо, малчин өрхийн анхдагч холбооны байгуулсан бэлчээр ашиглуулах гэрээг бүртгэх, гэрээг сумын газрын мэдээллийн нэгдсэн санд оруулах ажилд хяналт тавих, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх;

7.2.6.Бэлчээр ашиглуулах гэрээ боловсруулах, байгуулах, хэрэгжилт, биелэлтийг дүгнэх чиглэлээр холбогдох албан тушаалтан, байгууллага, малчдыг мэдээллээр хангах.

7.2.7.Газрын тухай хуулийн 58.5 дахь хэсэгт заасны дагуу бэлчээр, хадлангийн газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг 5 жил тутамд мэргэжлийн байгууллагаар хийлгэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих, дүнг мэдээлэх;

7.2.8.Сумын Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэгт малчдын оролцоог хангах, төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих үйл ажиллагаанд шаардагдах зардал, хугацааг тодорхой тогтоож, тусгах

7.3.Сумын цаг уурын харуул дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ:

7.3.1.Сум, багийн түвшинд бэлчээрийн мониторинг хийх, даацыг тодорхойлж, холбогдох байгууллага, албан тушаалтан, малчдад мэдээлэх;

7.3.2.Богино урт хугацааны цаг агаарын болон гамшигт үзэгдлийн урьдчилсан мэдээг сумын удирдлагууд, мэргэжилтнүүд, бэлчээр ашиглагчдад тогтмол хүргэх

7.3.3.Ган, зудыг эртнээс сэрэмжлүүлэх чиглэлээр үндэсний хэмжээнд баг бүрээр боловсруулан гаргадаг өвөл-хаврын бэлчээрийн даац болон зудын эрсдлийн үнэлгээг орон нутгийн удирдлагууд болон бэлчээр ашиглагчдад танилцуулах;

7.3.4.Бэлчээрийн өнөөгийн төлөв байдал болон цөлжилтийн үнэлгээний мэдээллийг орон нутгийн удирдлагууд болон бэлчээр ашиглагчдад хүргэх;

7.3.5.Цөлжилтөөс сэргийлэх, цөлжилтийг сааруулах, цөлжилттэй тэмцэх талаар уламжлалт болон шинжлэх ухаанд суурилсан мэдлэгийг ард иргэдэд эзэмшүүлэх ажлыг эрчимжүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах;

7.4.Сумын Мал эмнэлэгийн тасаг дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

7.4.1.Өөр аймаг, сумаас зөвшөөрөлгүй сумд отроор ирэх өрхийн мэдээллийг мал эмнэлэгийн нэгдсэн системээр шалгах, анхааруулах, буцаах ажлыг зохион байгуулах

7.4.2.Өөр аймаг, сумаас зөвшөөрөлгүй орж ирсэн тохиодолд мал эмнэлэгийн үйлчилгээнд хамрагдсан эсэхийг шалгах, шаардлага тавих;

7.4.3.Зохих хууль тогтоомжын дагуу зөвшөөрөлтэй орж ирсэн тохиолдолд мал сүрэгт мал эмнэлэгийн үйлчилгээ үзүүлэх;

7.5.Байгаль орчны тасаг дараах арга хэмжээ хэрэгжүүлнэ.

7.5.1.Бэлчээрийн экосистемийн тэнцвэрт байдлыг хамгаалах, бэлчээрийн ургамлыг байгалийн аясаар сэргэх боломжийг бүрдүүлэх;

7.5.2.Бэлчээр ашиглах, хамгаалахад ногоон хөгжлийн зорилтыг тусгах, төр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хамтын ажиллагаа, хүчин чармайлтыг чиглүүлэх;

7.5.3.Тухайн сумын усны нөөц ашигласны төлбөрийн эх үүсвэрээс гадаргын болон гүний усны нөөцийг зохистой ашиглах, хомсдол, бохирдлоос хамгаалах, нөхөх арга хэмжээ, санхүүжилтийн санал боловсруулж, сумын Засаг даргад өргөн барих;

7.5.4. Аймаг, сумын нутаг дэвсгэрт нүүдлийн биологийн зүйлийн амьдрах орчин, холбоос нутаг болон тусгай хамгаалалттай газар нутгийн дэглэм, горим, зэрлэг амьтны идэш тэжээлийг харгалзсан улирлын бэлчээр, байгалийн хадланг сэлгэж хадах хуваарийг тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулах чиглэлээр газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах ажлын хэсэгт мэргэжлийн зөвлөгөө өгөх, хэрэгжилтэд хамтарсан хяналт тавих;

Найм. Маргаан шийдвэрлэх, хохирол нөхөн төлүүлэх.

8.1. Бэлчээр ашиглах асуудлаар гарсан аливаа маргааныг маргалдагч талууд болон багийн иргэдийн Нийтийн Хурлын дарга, зөвлөл, багийн Засаг дарга, бэлчээр ашиглагч малчдын бүлэг, хоршоо, малчин өрхийн анхдагч холбоон ахлагч нарын төлөөллийг байлцуулан зөвшилцөж, журмын хүрээнд эвлэрлийн замаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ.

8.2. Маргалдагч талууд эс тохиролцсон тохиолдолд сумын Засаг даргын хуулиар олгогдсон эрх, үүргийн хүрээнд хуулийн дагуу маргааныг шийдвэрлэнэ.

8.3. Бэлчээрт учирсан хохирлыг мэргэжлийн байгууллагаар экологи, эдийн засгийн үнэлгээг тогтоолгож, буруутай этгээдээр нөхөн төлүүлэх асуудлыг холбогдох хууль, журмын хүрээнд шийдвэрлүүлнэ.

8.4. Энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд Зөрчлийн тухай болон бусад хуулийн холбогдох зүйл, заалтыг үндэслэн хариуцлага хүлээлгэнэ.

Ес. Журам хүчин төгөлдөр болох.

9.1. Энэхүү журмыг Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэгт заасны дагуу захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, захиргааны хэм хэмжээний актын эмхтгэлд нийтэлсний дараа хүчин төгөлдөр дагаж мөрдүүлнэ.

**БАЯНХОНГОР АЙМГИЙН
БУУЦАГААН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2026 оны 3 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 07/48

Буянт

**ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫГ ЦУГЛУУЛЖ, ТЭЭВЭРЛЭХ ЗАРДЛЫН
НЭГЖ ТАРИФ, ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14, 48 дугаар зүйлийн 48.1, 77 дугаар зүйлийн 77.1, Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 64 дүгээр зүйлийн 64.6, Татварын Ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1, 9.2.2, 41 дүгээр зүйлийн 41.5, 41.6 дахь заалтууд, Сангийн сайд, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын хамтарсан 2018 оны 7 дугаар сарын 19-ний өдрийн 192, А/243 дугаар тушаалыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2026 оны ээлжит долдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Сумын нутаг дэвсгэрт мөрдөх энгийн хог хаягдлыг цуглуулж,тээвэрлэх зардлын нэгж тарифыг нэгдүгээр, нэг иргэнээр тооцсон айл өрхийн хэрэглээнээс үүссэн энгийн хог хаягдлын хураамжийн хэмжээг хоёрдугаар, аж ахуйн нэгж байгууллагаас үүссэн энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг гуравдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2.Сумын нутаг дэвсгэрт батлагдсан хог хаягдлын үйлчилгээний хураамжийг мөрдүүлж, орлогыг Хог хаягдлын хураамжийн 100030400947 дансанд төвлөрүүлэн зарцуулалт, тайлагналтад байнгын хяналт тавьж, сумын Иргэдийн Төлөөлөгчийн Хуралд жил бүр тайлагнаж ажиллахыг сумын Засаг дарга (Х.Дагвадорж)-д үүрэг болгосугай.

3.Уг тогтоолыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, Улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (М.Сарантуяа)-д даалгасугай.

4.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн А/19 дугаартай тогтоол, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 04/28 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Ш.ТҮВШИН

*Бууцагаан сумын иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2026 оны 3 дугаар сарын 30–ны
өдрийн 7/48 дугаар тогтоолын нэгдүгээр
хавсралт*

**БУУЦАГААН СУМЫН ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫГ ЦУГЛУУЛЖ,
ТЭЭВЭРЛЭХ ЗАРДЛЫН НЭГЖ ТАРИФ**

№	Үзүүлэлтүүд		Нэгж	Тоо хэмжээ
1	2		3	4
1	A	Нэг рейсийн тээвэрлэлтийн дундаж зай	км	5
2	B	Хөдөлгөөний үеийн шатахууны зарцуулалтын норм	Км/л	0.35
3	C	Нэг рейсд хөдөлгөөний үеийн шатахуун зарцуулалтын дундаж	Км/л	0.0175
4	D	Ачилтын үеийн шатахуун зарцуулалтын норм	Мин/л	0.1
5	E	Ачилтын үеийн цаг ашиглалт	мин	75
6	F	Ачилтын үеийн шатахуун зарцуулалт	Мин/л	7.5
7	G	Шатахууны үнэ	төг/л	3840
8	H	Нэг рейст зарцуулах шатахуун	төг/л	28867
9	I	Ажиллах хугацааны үндсэн цалин	төг/рейс	20000
10	J	Ажилтны багаж хэрэгсэл	төг/рейс	2417
11	K	Нэг рейст шаардагдах зардал	төг/рейс	57951
12	L	Тээврийн хэрэгслийн элэгдлийн зардал	төг/рейс	2500
13	M	Тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээний зардал	төг/рейс	4167
14	N	Нэг рейст ачиж тээвэрлэх хогийн дундаж хэмжээ	төг/тн	4
15	O	Нэг тонн хогийг тээвэрлэх зардал	тн/төг	14488

Тайлбар: Сангийн сайд, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын хамтарсан тушаалаар батлагдсан аргачлалаар тооцов.

*Бууцагаан сумын иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2026 оны 3 дугаар сарын 30–ны
өдрийн 7/48 дугаар тогтоолын хоёрдугаар
хавсралт*

**ИРГЭН, ӨРХИЙН ХЭРЭГЛЭЭНЭЭС ҮҮССЭН ЭНГИЙН ХОГ
ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГ САРЫН ХУРААМЖИЙН
ХЭМЖЭЭ**

Д/д	Хураамжийн төрөл	Хураамжийн хэмжээ (төгрөг)
1	2	3
1	Өрхийн энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамж (дундаж 4 ам бүлтэй өрхөөр тооцов)	10,000

Тайлбар:

1. Айл өрхийн хэрэглээнээс үүсэх энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээ: (Хог хаягдлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.6 дах заалт “Айл өрхийн хэрэглээнээс үүсэх энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг нэг иргэнээр тооцно”)

2. Нэг өрхийн дундаж ам бүлийн тоог 2025 оны хүн амын тооллогын статистик үзүүлэлтийг үндэслэн 4 хүнтэй байхаар тооцсон.

3. Сангийн сайд, Байгаль орчин, Аялал жуулчлалын сайдын хамтарсан 2018 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 192, А/243 дугаар тушаалаар батлагдсан аргачлалын дагуу тооцож, нэг иргэнд ноогдох хог хаягдлын хураамжийг 2,500 төгрөг байхаар гаргаж, өрхийн дундаж ам бүлд харьцуулан нэг өрхөөс 10,000 төгрөгийн хураамж төлөхөөр тооцсон болно.

*Бууцагаан сумын иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын 2026 оны 3 дугаар сарын 30–ны
өдрийн 7/48 дугаар тогтоолын гуравдугаар
хавсралт*

**АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН ХЭРЭГЛЭЭНЭЭС ҮҮССЭН
ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГ САРЫН
ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭ**

Аж ахуйн нэгж байгууллагын төрөл, ангилал		Хог хаягдлын хураамжийн хэлбэр	Хэмжих нэгж	Нэг сарын хог, хаягдлын хураамжийн үнэ (төгрөг)
1.Төрийн байгууллага				
1.1	Засаг даргын Тамгын газар	Тогтмол	сар	25,000
1.2	Ерөнхий боловсролын сургууль	Тогтмол	сар	30,000
1.3	Цэцэрлэг, ясли	Тогтмол	сар	30,000
1.4	Эмнэлэг	Тогтмол	сар	25,000
1.5	Соёлын төв	Тогтмол	сар	20,000
1.6	Гал түймэр унтраах, аврах 72 дугаар анги	Тогтмол	сар	20,000
2.Худалдаа				
2.1	мини маркет	Тогтмол	сар	20,000
2.2	хүнсний дэлгүүр	Тогтмол	сар	15,000
2.3	төрөлжсөн барааны дэлгүүр	Тогтмол	сар	15,000
2.5	бусад	Тогтмол	сар	15000
3. Хоол үйлдвэрлэл үйлчилгээ				
3.1	караоке	Тогтмол	сар	25,000
3.2	цайны газар (Нийтийн үйлчилгээтэй болон)	Тогтмол	сар	25,000
3.3	кофе шоп	Тогтмол	сар	20,000
4. Ахуйн үйлчилгээ				
4.1	үсчин	Тогтмол	сар	25,000
4.2	нийтийн халуун ус	Тогтмол	сар	25,000
4.3	бусад	Тогтмол	сар	20,000
5. Зочлох үйлчилгээ				
5.1	зочид буудал	Тогтмол	сар	30,000
5.2	амралтын газар	Тогтмол	сар	50,000
5.3	гэр буудал	Тогтмол	сар	30,000
5.4	бусад	Тогтмол	сар	30,000
6. Авто үйлчилгээ				
6.1	дугуй засвар	Тогтмол	сар	25,000

6.2	шатахуун түгээх станц	Тогтмол	сар	25,000
6.3	бусад	Тогтмол	сар	20,000
7. Бусад байгууллага				
7.1	Банкны бүх салбарууд	Тогтмол	сар	25,000
7.2	Эмийн сан	Тогтмол	Сар	20,000
7.3	Уурын зуух	Тогтмол	Сар	гэрээгээр
8. Мал дайвар бүтээгдэхүүний чиглэлээр				
8.1	Дахивар авах иргэн	Тогтмол	Сар	50,000
8.2	Ашиг олох зорилгоор мал нядалсан иргэн	Сар	1 бог	300
9. Уул уурхай, түгээмэл тархацтай ашигт малтмалын чиглэлээр				
9.1	Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж	Ажилласан сар бүр	Сар	300,000
9.2	Хайрга дайрганы олборлолт, хайгуулын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж	Ажилласан сар бүр	Сар	80,000
9.3	Бусад (төслийн нэгж, замын ажил гэх мэт)	Ажилласан сар бүр	Сар	100,000

Тайлбар:

1. Дээрх тогтмол хураамжийн хэмжээ нь нэг сард аж ахуй нэгж, байгууллагаас энгийн хог хаягдал ачиж тээвэрлэх тариф бөгөөд сард ачиж тээвэрлэх давтамж нь хогны гарцаас шалтгаалан 1-4 удаа байна.

БУЛГАН АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 3 дугаар
сарын 31-ний өдөр

Дугаар XIII/94

Булган
сум

УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭ ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10 дахь заалт, 35.1.14 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.14 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ес дэх удаагийн сонгуулийн ээлжит XIII хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Орон нутгийн хот доторх болон хот орчмын нийтийн зорчигч тээвэр, такси үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тэмдэгтийн хураамжийн хэмжээг 3 000 000 (гурван сая) төгрөгөөр тогтоосугай.

2.Улсын тэмдэгтийн хураамжийн хувь хэмжээг батлагдсан хэмжээгээр тооцож ажиллахыг аймгийн Засаг дарга (Д.Пүрэв-Очир)-д даалгасугай.

3.Улсын тэмдэгтийн хураамжийн орлого бүрдүүлэлтэд хяналт тавьж ажиллахыг Татварын газрын дарга (Д.Лхагвасүрэн)-д, тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Эдийн засаг, бүсчилсэн хөгжлийн хороонд тус тус даалгасугай.

4.Улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээг 2026 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдсүгэй.

5. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Улсын тэмдэгтийн хураамжийн хэмжээ тогтоох тухай” 2025 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн IX/66 дугаартай тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Ж.ГАНБОЛД

БУЛГАН АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 3 дугаар
сарын 31-ний өдөр

Дугаар XIII/95

Булган
сум

АГААРЫН БОХИРДЛЫН ТӨЛБӨРИЙН ХУВЬ ХЭМЖЭЭГ ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10 дахь заалт, 35 дугаар зүйлийн 35.1.14 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Татварын ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэг, Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.2, 7.4 дэх хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ес дэх удаагийн сонгуулийн ээлжит XIII хуралдаанаас **ТОГТООХ** нь:

1.Булган аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа агаар бохирдуулагчаар төлүүлэх агаарын бохирдлын төлбөрийн хувь хэмжээг хавсралтаар баталсугай.

2.Тус тогтоолыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (О.Наранжаргал)-д даалгасугай.

3.Агаар бохирдуулагчид ногдуулсан агаарын бохирдлын хувь хэмжээг мөрдүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Татварын газрын дарга (Д.Лхагвасүрэн)-д үүрэг болгосугай.

4.Энэхүү тогтоолыг 2026 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

5.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Агаарын бохирдлын төлбөрийн хувь хэмжээг тогтоох тухай” 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 12/88 дугаартай тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Ж.ГАНБОЛД

*Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
ес дэх удаагийн сонгуулийн ээлжит XIII
хуралдааны 95 дугаар тогтоолын хавсралт*

АГААРЫН БОХИРДЛЫН ТӨЛБӨРИЙН ХУВЬ ХЭМЖЭЭ

№	Агаарын бохирдлын төлбөр ногдох төрөл		Зэрэглэл, ангилал	Төлбөрийн хувь хэмжээ /төгрөг/
1.	Олборлосон түүхий нүүрс / килограмм тутамд/			1
2.	Үйлдвэрлэсэн болон импортолсон органик уусгагч	Үйлдвэрлэсэн органик уусгагч /килограмм тутамд/	Зэрэглэл-1	30
			Зэрэглэл-2	20
			Зэрэглэл-3	10
		Импортолсон органик уусгагч /килограмм тутамд/	Зэрэглэл-1	30
			Зэрэглэл-2	20
			Зэрэглэл-3	10
3.	Агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэрээс агаарт гаргах хаягдал /килограмм тутамд/		1-р зэрэг	10
			2-р зэрэг	5
			3-р зэрэг	2
			4-р зэрэг	1

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ТӨГРӨГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 3 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 03

Төгрөг

БЭЛЧЭЭРИЙГ УЛИРЛААР АШИГЛАХ ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэр нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.14 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1, 52.2, 52.4 дэх хэсгийг тус тус үндэслэн тогтоох нь:

- 1.Бэлчээрийг улирлаар ашиглах журмыг хавсралтаар баталсугай.
- 2.Бэлчээрийг улирлаар ашиглах журмыг захиргааны хэм хэмжээний актад бүртгүүлэх ажлыг сумын Засаг дарга (Р.Жанлав)-д даалгасугай.
- 3.Бэлчээрийг улирлаар ашиглах журмыг ард иргэдэд тайлбарлан, мөрдөж ажиллахыг сумын Засаг дарга (Р.Жанлав), Хөдөө аж ахуйн тасгийн бэлчээр, газар тариалан хариуцсан мэргэжилтэн (Н.Амгаланбаатар), багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.
- 4.Журмын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн хороонд даалгасугай.
- 5.Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 14 дүгээр тогтоолыг хүчингүйд тооцсугай.
- 6.Уг тогтоолыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, нийтэлсний дараа дагаж мөрдсүгэй.

ДАРГА

Д.ДЭЧИН

*Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2026 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн
03 дугаар тогтоолын хавсралт*

ТӨГРӨГ СУМЫН БЭЛЧЭЭРИЙГ УЛИРЛААР АШИГЛАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Бэлчээрийг орон нутгийн бэлчээрийн экологийн чадавхад суурилсан аргачлалаар улирлын хуваарьтай төлөвлөх, бэлчээрийн даац, багтаамжид тохируулан малын тоо толгойн зохистой хэмжээг бий болгож, бэлчээр байгалийн жамаараа нөхөн сэргэх боломжийг бүрдүүлэх, зүй зохистой ашиглах, хамгаалахад нутгийн захиргаа, малчдын хооронд үүсэх харилцааг энэхүү журмаар зохицуулахад оршино.

1.2.Газрын тухай хуулийн 50.1.1-т заасны дагуу бэлчээрийн төлөв байдал чанарыг хадгалах, хөрсний үржил шим буурах, бэлчээрийн ургамлын бүрхэвч талхлагдаж хөрс элэгдэх, эвдрэх, хуурайших, намагших, давсжих, бохирдохоос сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын тодорхой хувийг бэлчээр ашиглагч малчин хариуцна.

1.3.Сумын нутаг дэвсгэрт Монгол Улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Газрын тухай хууль, Зөрчлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжуудын хэрэгжилтийг хангахад бэлчээр, ус ашиглагч малчид, бүлэг, хоршоо, нөхөрлөлүүд энэхүү журмыг мөрдлөг болгон ажиллана.

Журмын зорилт

Энэ журмын зорилт нь сумын газар нутгийг улирлаар ашиглах, газрын талхагдал, бэлчээрийн доройтлыг багасгах, газар нутгаа тэлж нутаглахыг зохицуулахад оршино.

Хоёр.Бэлчээрийг улирлаар ашиглах хугацаа

Өвөлжөө: 11 дүгээр сарын 15-наас 03 дугаар сарын 01

Хаваржаа: 03 дугаар сарын 01-нээс 06 дугаар сарын 01

Зуслан: 06 дугаар сарын 01-нээс 09 дүгээр сарын 15

Намаржаа: 09 дүгээр сарын 15-наас 11 дүгээр сарын 15

Гурав.Бэлчээрийн улирлын хуваарь газрын нэршлээр

Өвөлжөө

Хүрэнгол баг: Өвчүү, Таг, Улаан энгэр, Уулангийн гол, Хужирт, Цахир салаа, Ямаан ус, Дээд доод цагаан өтөг, Далт, Улаан хад, Нөмөр, Хөрөлт, Айргийн хад, Бараан хөндий, Шавартын бэлчир, Оройн өтөг, Амгалан, Ширдэгт, Нурамт, Бэлийн өтөг, Толгойн өтөг, Хүүш, Бинт,

Хөвийн ам , Хужирт, Хөх толгой, Хавчгийн ам, Хэрцийн ам, Гашуун, Бэлчир, Бараан хад, Улаан үзүүр, Цахир салаа

Төгрөгийн эх баг: Бор үзүүр, Хавчиг өтөг, Олон овоот, Ханан хад, Ташгай, Дөрвөлжин ханан хад, Хөх нурамт, Өвчүү, Ихэр дээд, доод, Улаан толгой, Ар завсар, Ишиг майлдаг, Далайн мухар, Эрхмийн цагаан, Хөх хад, Индэрт, Бунданд худаг, Таг жалга, Бараан эрэг

Мааньт баг: Дээд доод шанд, Доод өвт, Тохойн улаан хад, Тохойн хүрэн хад, Хар хөндий, Ёлын худаг, Ёлын эх, Бурхант, Нурамт, Хавтгай улаан, Мухар хашаат , Цагаан өтөг, Улаан хад, Хөшөөгийн дэвсэг, Хөх хад, Мараат, Хөх энгэр, Ширдэгт, Цахир нүхэн, Үнхэлцэг, Улаан жалга, Уусар, Үхэр чулуут, Ихэр, Ягаан хөндий

Цагаанхайрхан баг: Улаан энгэрийн ам, Их огторгын өвөлжөөнүүд, Цахир толгой, Хөх жалга, Огторгын худаг, Гэдгэрийн улаан хад, Хөх энгэр, Шанаганы орой, Улаан богч, Алаг бухтын цагаан, Лодой ам, Цэцэрлэгийн ам, Дэрсэн өтөг, Чугантын ам, Үзүүрийн буудал, Шур, Харын завсар, Сэнжит, Хойт, Дунд хөх толгой, Улаан хад, Нурамт, Шар хөндийн ам, Булшт, Улаан булаг, Хар цагааны ам, Сүмбэр, Барзан, Хойт, Урд бор үзүүр, Шанд, Толь, Толийн энгэр, Их өтгийн Дээд, Дунд, Доод буудал, Хужиртын ам, Угалзын ам, Бөөр, Хавчгийн худаг, Жасын нутаг, Улаан толгой, Ямаан ус, Цахир толгой, Ихэр, Цагаан жалга, Хүүшийн бэлчир, Бургасны хөх энгэр, Ихэр, Нөмрийн Дэд, Доод буудал, Шанаган ам, Бургасны улаан хад, Алаг бухтын цагаан

Тунгалаг баг: Өгөөмөр, Тунгалаг, Төхөм, Арсай, Давсан сондог, Хаяа, Баянбулаг

Хаваржаа

Хүрэнгол баг: Үзүүрийн худаг, Гүн худгаас доош, Лхүндэв, Хар ганга, Толийн бэлээс доош, Бор нурууны худагаас дээших хаваржаанууд, Үертийн ам, Бударгана, Цанхилахын ам, Жалман, Хар чулуут, Толь

Төгрөгийн эх баг: Энгэрийн хар чулуут, Улаан жалга, Зөрүү, Аман хашаат, Саарайн улаан хад, Дунд хашаа, Сээвийн хашаа, Улаан хашаат, Хөшөөтийн ам, Хөшөөтийн улаан жалга, Хөшөөтийн шовгор, Бүлтгэр, Араагын худаг, Нүдэнгийн энгэр

Мааньт баг: Хойз, Дээд, Доод, Дунд нүүр, Улаан ганга, гурван хашаа, Дашнямын хашаа, Пүрэвдоогийн хашаа, Шар толгой, Шар хөтөл, Талын худаг, Шандны худаг, Цахир хүзүүвч, Өлийн худаг, Төгрөгийн ам, Шилийн бааз, Мааньтын ам, Урд өндөр толгой орчмын хаваржаанууд

Цагаанхайрхан баг: Нийлэгч, Далан түрүүний эх, Хойт өндөр толгой, Шилүүстэйн ганганы буудал, Дэвсэгийн улаан хад, Хавтгай улаан, Намаржаан, Мааньтын амны цахир толгой, Хараас доош, Далан түрүүнээс урагш, Сайраас хойших хаваржаанууд, Загийн ус, Хөх худаг,

Угалзын бэлчир, Гозгор хад, Улаан асга, Ондгорын цагаан, Хоёр худаг, байшингийн хонхор, Энгэрийн буудал, Ихэр, Хэцийн хөтөл, Хавчигийн бэлчир, Гэдгэр

Тунгалаг баг: Хармагийн худаг, Төхөм, Арсай, Тунгалаг, Ишиг, Шагшиг, Алаг толгой, Өгөөмөр, Шинэ худаг, Хар ганга, Яхын далан, Хөх тэсэг, Загийн худаг, Бор нурууны худаг

Зуслан

Хүрэнгол баг: Шаварт, Хөндлөн булаг, Цагаан булаг, Бага хавчиг, Наган, Юмын булаг, Түргэн, Овоот, Дэвхрэг, Хатуу, Цагаан булаг, Боом, Өвөр цагаан булаг, Хавцгайт, Завсрийн булаг, Их хавчиг

Төгрөгийн эх баг: Зуслангийн гол, Зочийн гол, Хөх жалга, Урд хойд шанд, Хавцгайтын эх, Бунхан, Төгрөгийн эх, Хөх сайр, Жаргалт, Хар үзүүр, Уст, Хөшөөтийн гол

Мааньт баг: Хөх асга, Угалзын гол, Мөстийн хойд урд салаа, Шилэн Мааньтын хөтлийн их хашаа

Цагаанхайрхан баг: Элсэн тохой, Алаг овоот, Хар үзүүр, Энгэрийн буудал, Хүнхэрийн ам, Хөшөөтийн ар ам, Асгатын гол, Нарийн хамар, Санзай, Бургасны эх, Хөх худаг, Хужирт, Цахир булаг, Дэвсэг

Тунгалаг баг: Цагаан дэрс, Бударгана, Талын худаг, Далантүрүү, Цанхилахын ам, Бургасан ам, Үзүүрийн худаг, Төгрөгийн ам

Намаржаа

Хүрэн гол баг: Үертийн ам, Цанхилах амны хойт дэнж, Цахир худаг, Бумбат, Бударгана, Цахир худаг

Төгрөгийн эх баг: Сухант, Тасархай, Бөөн сухай, Бор булаг, Сондогтын ам, Чавчаал, Цахир булаг, Мухар Хулстай, Хүн толгойт уул, Далт уул, Талын улаан, Нусхайн хар үзүүр, Хавцгайт, Сухантын хар уул, Шийрийн улаан

Мааньт баг: Аман ташуу, Шивээт, Мааньтын хөтөл, Өргөө, Бор завсар, Шилэн, Шар толгой, Ганга, Ондгор, Өвчүү, Шинэ ус, Хойз, Дээд, Доод, Дунд нүүр, Улаан ганга, Гурван хашаа, Дашнямын хашаа, Пүрэвдоогийн хашаа, Шилийн бааз, Мааньтын ам

Цагаанхайрхан баг: Далан түрүүний хоёр гол, Шилүүстэйн ганганы буудал, Хар хуруу, Махтын сайрын ихэр, Хөх толгой, Бургасны ам, Хотгор харгана, Эргэнэ буудал, Загийн ус, Тасархай, Бургасан амны хойт хотос, Хойт өндөр толгой, Төгрөгийн сайр, Мааньтын амнаас хойш

Тунгалаг: Цагаан дэрс, Бударгана, Талын худаг, Далан түрүү, Цанхилахын ам, Бургасан ам, Үзүүрийн худаг, Төгрөгийн ам, Загын ус

Дөрөв.Бэлчээрийг улирлаар ашиглах журмыг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим

4.1.Бэлчээр улирлаар ашиглах журмыг хэрэгжүүлэхдээ дараах

зарчмыг баримтлана.

4.1.1.Бэлчээрийн даац, багтаамж, экологийн чадавхид суурилах

4.1.2.Бэлчээр ашиглагчдын тэгш оролцоог хангах

4.2.“Бэлчээрийг улирлаар ашиглалтын журам” нь дараах шаардлагыг хангасан байна.

4.2.1.Бэлчээрийн төлөв байдал чанарт хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний /фотомониторинг гэх/ дүнд үндэслэсэн байна.

4.2.2.Бэлчээрийг улирлаар ашиглах, сэлгэх, өнжөөх хуваарь гаргана.

4.2.3.Тариалангийн талбайгаас 500-1000 метрээс дотогш бүсийг тариалангийн бүс гэж үзнэ.

4.2.4.Уст цэг, хужир мараа бүхий газрыг нийтээр ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ.

4.2.5.Худалдан авсан нядалгааны малыг өвөлжөө, хаваржаа, намаржааны бүс нутагт байлгахыг хориглож, сумын хилийн цэс бүсрүү шахаж бэлчээр зааж өгнө.

4.2.6 Өвлийн улиралд хашаандаа мал тэжээхээс бусад үед сумын төвд мал байлгахыг хориглоно.

Тав.Бэлчээрийг улирлаар ашиглах журмыг хэрэгжүүлэхэд оролцогч талуудын хүлээх үүрэг

5.1.Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал дараах үүрэг хүлээнэ.

5.1.1.Багийн иргэдийн Нийтийн Хурлын саналыг үндэслэн Газрын тухай хуулийн 20.1.2, 52.6-д заасны дагуу сумын тухайн жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг нутаг дэвсгэрийн тусгайлан (өвөлжөө, хаваржаа, намаржаа хадлангийн талбай, отрын, өнжөөх, чөлөөлөх) болон нийтээр зусах бэлчээрийн заагийг тогтоож сумын Засаг дарга өргөн мэдүүлснийг хэлэлцэж шийдвэрлэнэ.

5.1.2.Сумын бэлчээрийн даацад нийцсэн сүргийн зохистой бүтэц, малын тооны оновчтой хэмжээг тогтоож батлах, авах арга хэмжээний чиглэлийг батлаж, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, жил бүрийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх

5.1.3.Бэлчээр улирлаар ашиглах журмыг үлгэр жишээ мөрдөж буй малчдыг бодлогоор дэмжих, шагнаж урамшуулах

5.2.Сумын Засаг дарга дараах үүрэг хүлээнэ.

5.2.1.Бэлчээр болон ус ашиглалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг багийн Засаг даргатай хамтран зохион байгуулах, шалгах, тайлагнах

5.2.2.Багийн Засаг даргын жилийн ажлыг үнэлэхдээ энэ журмын хэрэгжилтийн үр дүнг тооцох

5.2.3.Гол, горхи, булаг, шандын эх ундарга, хадлангийн болон тариалангийн талбай хамгаалах, нөхөн сэргээх, сайжруулах сургалтыг

зохион байгуулах

5.2.4.Гантай эсхүл өвөлжилт хүндэрсэн өөрийн сумын багаас бэлчээрийн даац хүрэлцээтэй багийн нутаг дэвсгэрт айл өрх мал сүргийг тухайн багийн Засаг даргатай зөвшилцөн оруулах шийдвэр гаргах

5.2.5.Малчид, малчдын бүлэгт нэг наст болон олон наст ургамал тариалах, тариалангийн бүс нутагт эрчимжсэн мал аж ахуй төрөлжүүлэн хөгжүүлэх зэрэгт бодлогоор дэмжих, арга зүйгээр хангах

5.2.6.Отроор ирсэн малчидтай “Бэлчээр ашиглуулах гэрээ” байгуулна.

5.2.7.Бэлчээрт мониторингийн судалгаа хийх, үүлэнд нөлөөлөх генератор байрлуулах саналыг аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний газарт хүргүүлнэ.

5.2.8.Хаваржаа, намаржааны бүс нутагт хамаарах Бумбатын ам,Үерт,Цагаан дэрс, Үзүүрийн худаг,Талын худаг,Бударгана, Төгрөгийн ам, Далан түрүү, Хойз, Өлийн худагт бог малтай зусахыг хориглоно.

5.2.9.Бод мал их хэмжээгээр орж ирсэн бусад сумын удирдлагуудад хугацаатай албан бичиг хүргүүлэх

5.3.Багийн Засаг дарга дараах үүрэг хүлээнэ.

5.3.1.Сумын тухайн жилийн бэлчээр ашиглалтын төлөвлөгөөг үндэслэн өөрийн багийн нутаг дэвсгэрт тусгайлан болон нийтээр ашиглах бэлчээр усны хуваарь, заагийг хот айл, малчдын бүлэгтэй тус бүрээр нарийвчлан тохирч гэрээ байгуулах, сумын Засаг даргад тайлагнах

5.3.2.Хоршоо, нөхөрлөл, бүлэгтэй “Бэлчээрийг ашиглуулах гэрээ” байгуулах, гэрээнийхээ хэрэгжилтийг хангах

5.3.3.Отрын (гэрээ, зөвшөөрөл, мал эмнэлгийн үйлчилгээний бичиг)-гүй орж ирсэн малчидтай нэн даруй уулзаж, шаардлага өгч, нүүлгэх, нутаг бэлчээр олгохгүй байх.

5.3.4.Бэлчээрийн хөнөөлт мэрэгчид, хортон шавьжтай тэмцэх ажлын хүрээнд тандалт судалгааг малчид болон малчдын бүлэгтэй хамтран хийж, сумын Хөдөө аж ахуйн тасаг болон нийтийг хамруулан тэмцэх ажлыг зохион байгуулах

5.3.5.Малын тоо толгойг бэлчээрийн даацад нийцүүлэхэд чиглэсэн сүргийн зохистой бүтэц, харьцаа, үүлдэр угсаа, шилэн сонголт, чанар сайжруулахад анхаарч ажиллах, мал эмнэлгийн тусламж үйлчилгээнд малчдыг бүрэн хамруулах.

5.3.6.“Бэлчээрийг улирлаар ашиглах журам” зөрчсөн этгээдэд хугацаатай мэдэгдэх хуудас өгч, сумын Засаг даргад нэн даруй мэдэгдэх

5.3.7.Сум, багийн нутаг дэвсгэрт орж ирсэн бусад сумын бод малыг буцаан авах хугацаатай үүрэг даалгавар өгч хугацаа хэтэрсэн

тохиолдолд сумын нутаг дэвсгэрээс хөөн гаргаж ажлыг зохион байгуулах

5.3.8.Бэлчээрийг хуваарийн дагуу чөлөөлөөгүй этгээдийг албадан нүүлгэж, гарсан зардлыг төлүүлэх

5.3.9 Отроор мал оруулж ирж өвөлжүүлэхдээ багийн ИНХ-аар хэлэлцэж оруулах

5.3.10 Багийн Засаг дарга нар багийн хилийн цэсийн байршлыг багийнхаа болон бусад багийн малчдад нарийн зааж өгөх

5.4.Сумын Мал эмнэлэгийн тасгийн улсын байцаагч дараах үүрэг хүлээнэ.

5.4.1.Сумын нийт мал сүргийг элдэв паразит шимэгч хорхой халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг мал эмнэлгийн нэгжүүдтэй хамтран зохион байгуулах

5.4.2.Малын шилжилт хөдөлгөөн мал амьтны гаралтай хүнсний болон түүхий эд бүтээгдэхүүний ариун цэвэр аюулгүй байдалд баталгаажуулалтын хяналт, тогтмол хийх

5.4.3.Отрын малд гарал үүсэл, эрүүл ахуй, мал эмнэлгийн тасгийн байцаагчийн тодорхойлолтыг үндэслэх, шаардлагатай гэж үзвэл ариутгал халдваргүйжүүлэлт хийж сумын хилээр нэвтрүүлэх

5.5.Сумын Хөдөө аж ахуйн тасаг дараах үүрэг хүлээнэ.

5.5.1.Малчдад бэлчээр ашиглалтын ач холбогдлыг ойлгуулж, мэдлэг олгох, доройтсон бэлчээрийг нөхөн сэргээх сайжруулах талаар мэдээлэл өгч бэлчээрийг зөв зохистой ашиглах дадалтай болгох

5.5.2.Бэлчээрийн төлөв байдал, чанарт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлгэх, бэлчээр ашиглах, сэлгэх, өнжөөх хуваарийг боловсруулах

5.5.3.Бэлчээрийг хамгаалах, байгалийн жамаараа нөхөн сэргэх боломжийг бүрдүүлэх, бэлчээр дэх уст цэг, хужир мараа бүхий газрыг нийтээр ашиглах нөхцөлийг бүрдүүлэх ажлыг хэрэгжүүлэх

5.5.4.Нөөц нутаг бэлчээрийг ашиглах зайлшгүй шаардлага гарсан үед санал боловсруулж сумын Засаг даргад танилцуулах

5.5.5.Бэлчээрийн хөнөөлт мэрэгчид хортон шавьжтай тэмцэх ажлыг малчдын оролцоотой зохион байгуулах

5.5.6.Бэлчээрийн даац, багтаамжийн дүнд тулгуурлан тухайн жилд малын тоог бэлчээрийн даацад нийцүүлэхэд чиглэсэн сүргийн зохистой бүтэц, хэмжээ, сүргийн эргэлтийг оновчтой зохион байгуулж, мал аж ахуйг үр ашигтай эрхлэн явуулахад тоонд бус чанарт анхаарч өндөр ашиг шимтэй сумын цөм сүргийг бий болгож, малчид болон малчдад бүлэгт эцэг мал нийлүүлэх замаар шийдвэрлэх

5.6 Сумын цаг уурын харуул дараах үүрэг хүлээнэ.

5.6.1.Фотомониторингийн цэгийн тоо, бэлчээрийн даац

тодорхойлсон дүнгийн хамт жил бүрийн 9 дугаар сарын 20-ны дотор сум, багийн Засаг даргад хүргүүлэх

5.6.2.Цаг агаарын урьдчилсан мэдээллээр хангах, масс мэдээ илгээх

5.7.Газрын даамал дараах үүрэг хүлээнэ.

5.7.1.Малчин хоршоо, нөхөрлөл (бүлэг)-тэй бэлчээр, ус ашиглалтын гэрээ байгуулахад шаардагдах хавсралт, зурган мэдээлэл гаргаж өгөх, газрын мэдээллийн нэгдсэн санд давхцуулахгүй бүртгэх сумын Засаг даргад тайлагнах

5.7.2.Газрын тухай хуулийн 58.5 заасны дагуу бэлчээр, хадлангийн газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг 5 жил тутамд мэргэжлийн байгууллагаар хийлгэх

5.7.3.Сум болон багийн хилийн цэсийн байршлыг багийнхаа болон бусад багийн малчдад нарийн зааж өгөх

5.8.Мал аж ахуйн үйлдвэрлэлийн хяналтын улсын байцаагч дараах үүрэг хүлээнэ.

5.8.1.Сумын бэлчээр ашиглах журам зөрчсөн малчдад Мал аж ахуйн үйлдвэрлэлийн улсын байцаагч хугацаатай мэдэгдэх хуудас өгсөн өдрийн хугацаа дууссанаас хойш Зөрчлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалтыг үндэслэн торгуулийг ноогдуулна.

5.8.2.Худалдан авсан нядалгааны мал болон сумын төвд мал оруулж ирсэн малчдад болон энэхүү журмыг зөрчсөн иргэнд Мал аж ахуйн үйлдвэрлэлийн улсын байцаагч торгуулийг ногдуулна.

5.8.3.Өөр аймаг, сумаас МЭ-ийн үйлчилгээ, ариун цэврийн гарал үүслийн гэрчилгээгүй болон зөвшөөрөлгүй орж ирсэн тохиолдолд Мал эмнэлгийн улсын байцаагч торгуулийг ногдуулна.

Зургаа. Малчин дараах үүрэг хүлээнэ.

6.1.Бэлчээр ашиглагч малчин, хоршоо, нөхөрлөл, бүлэг дараах үүрэг хүлээнэ.

6.1.1.Бэлчээр ашиглалтын жилийн төлөвлөгөө боловсруулахад биечлэн оролцох

6.1.2.Бэлчээр өнжөөх, чөлөөлөх, сэлгэх, отор нүүдэл хийх талаар гаргасан сум, багийн Засаг даргын шийдвэрийг дагаж биелүүлэх.

6.1.3.Бэлчээр ашиглалтын төлөвлөгөөнд заасны дагуу сумын бэлчээрийн мониторингийн даацад тохирсон мал сүргийн зохистой бүтэц, малын тоо хэмжээнд өсгөн үржүүлэх.

6.1.4.Малын тоо толгойн татварыг сумын ИТХ-ын тогтоосон хэмжээгээр хуулийн хугацаанд төлөх.

6.1.5.Отрын айлыг дур мэдэн зөвшөөрөлгүй оруулж, өвөлжөө, хаваржаа, хот бууцыг дамжуулан ашиглуулахгүй, бэлчээр хашихгүй байх.

6.1.6.Сумын Засаг даргын зөвшөөрөлгүй шинээр хашаа, хороо барих, уст цэг гаргах, ашиглах, эзэмших бусдад өвөлжөө, хаваржааны газар олгох, худалдах, шилжүүлэх, бэлэглэхийг хориглоно.

6.1.7.Бэлчээр, хашаа, саравч, бууц, усны эх үүсвэрийг бохирдуулахгүй, малын сэг зэм, хог хаягдлыг цэвэрлэж, хортон мэрэгчтэй тэмцэх, сумын мал эмнэлгээр ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэж, устгах.

6.1.8.Бэлчээрийн даацаас илүү гарсан малыг тухайн жилийн мал тооллого хүртэлх хугацаанд зах зээлд борлуулах, цөөн тооны мал бүхий малчин өрхөд хөлсөөр маллуулах, бэлчээрийн даац бүхий өөр аймаг, сумдын нутагт отроор явах санаачлага гаргах.

6.1.9.Энэ журмын 4.2.3-д заасан зайд мал бэлчээхгүй, оторлохгүй, хашаа саравч барихгүй байх

6.1.10.Уст цэг, хужир мараа бүхий газрыг нийтээр ашиглах нөхцөлийг бүрдүүлэх.

6.1.11.Гал түймрээс урьдчилан сэргийлж, түүнтэй тэмцэх багаж хэрэгсэлтэй байх ба түймэр гарсан үед унтраах ажилд шуурхай орж холбогдох хүмүүст хэл хүргэх ажлыг зохион байгуулна.

Долоо.Отрын малчдын хүлээх үүрэг

7.1.Оторлож буй малчид нь сумын удирдлагын хууль ёсны гэрээг биелүүлэх талаар тавьсан шаардлагыг хэрэгжүүлж ажиллана.

7.2.Малын гоц халдварт, халдварт, паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх угаалга, тарилга, туулгалт, вакцинжуулалт, арьсны болон хамрын гуурын боловсруулалт хийх зэрэг мал эмнэлгийн арга хэмжээг технологийн хугацаанд нь чанартай бүрэн хийлгүүлэх, өвчин эмгэггүй, эрүүл байх үүнийг батлах харъяалах сумын мал эмнэлгийн гэрчилгээтэй байх ба өрхийн малын эрүүл мэндийн дэвтрийн хөтлөлтийг бүрэн хийлгэсэн байх

7.3.Зөвшөөрөгдсөн тооны бод, бог малыг тухайн заасан бүс нутагт оруулж, нэр зааж оноосон өвөлжөө, хаваржаанд нутаглана.

7.4.Өөрийн болон өөр аймаг, сумын нутаг дэвсгэрт оторлон яваа малчин, мал бүхий иргэд бусдын өвөлжөө, хаваржааны нутгийн бэлчээрийг чөлөөлж, малаа бэлчээрлүүлэхгүй байх

7.5.Оторт очсон малчид /иргэд/ тухайн бүс нутагт байгаа байгалийн баялаг, ан амьтныг хамгаалах, уст цэг, өвөлжөө, хаваржааны хашаа хороог бүрэн бүтэн ашиглаж, бэлчээрийн аливаа хог, сэг зэмийг устгаж, тухайн сумын удирдлага болон зөвлөлд хүлээлгэн өгнө.

Найм. Журам зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

8.1.Энэ журамыг зөрчигчдөд эхний удаа 1-3 хоногийн хугацаатай бэлчээрийг чөлөөлөх үүрэг даалгаврыг тухайн зөрчил гаргасан газрын багийн Засаг дарга албан ёсоор өгнө.

8.2.Хугацаатай үүрэг даалгавар аваад зөрчлөө арилгаагүй тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6. дахь заалтын дагуу шийтгэл ногдуулж, зөрчлийг арилгуулна.

8.3.Бод мал их хэмжээгээр орж ирсэн бусад сумын удирдлагуудад хугацаатай албан бичиг хүргүүлж, хугацаа дуусахад арга хэмжээ аваагүй тохиолдолт дээд шатны байгууллагаар шийдвэрлүүлнэ.

8.4.Шаардлагатай тохиолдолд хуулийн байгууллагаар шийдвэрлүүлнэ.

Ес. Журам хүчин төгөлдөр болох

Энэхүү журмыг Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2-т заасны дагуу захиргааны хэм хэмжээний актыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтэлсний дараа хүчин төгөлдөр болно. Хүчин төгөлдөр болсон цагаас эхлэн энэхүү журмыг дагаж мөрдөнө.

ДОРНОГОВЬ АЙМАГ
ӨРГӨН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 3 дугаар
сарын 31-ний өдөр

Дугаар 08/03

Сэнж

**ХОГ ХАЯГДЛЫН ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ
ТУХАЙ**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14, 48 дугаар зүйлийн 48.1, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2, 9.2.1, 9.2.2, 41 дүгээр зүйлийн 41.8, Татварын ерөнхий хуулийн 8 дүгээр зүйлийн 8.4, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1, 64.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Өргөн сумын хэмжээнд мөрдөгдөх энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг нэгдүгээр хавсралтаар, Энгийн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх зардлын нэгж тарифыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэхүү тогтоолын Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэлд нийтэлсний дараа өдрөөс эхлэн мөрдөн, олон нийтэд сурталчлан таниулж, хог хаягдлын менежментийг сайжруулан, хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төлөлтөд хяналт тавьж, орлогыг хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, булшлах үйл ажиллагаанд зарцуулж ажиллахыг сумын Засаг дарга (Т.Бат-Амгалан)-д даалгасугай

3.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн “Хог хаягдлын хураамжийн хэмжээг шинэчлэн батлах тухай” 10/07 дугаар тогтоолыг хүчингүй болгосонд тооцсугай.

4.Захиргааны хэм хэмжээний актын жагсаалтад бүртгэгдэн хүчин төгөлдөр болсноос хойш, Өргөн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 10/07 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

5.Захиргааны хэм хэмжээний актыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтэлсний дараа хүчин төгөлдөр дагаж мөрдүүлэхийг сумын Засаг дарга (Т.Бат-Амгалан)-д даалгасугай.

ДАРГА

С.БААТАРСҮРЭН

*Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2026 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн
08/03 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт*

ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭ

№	Хог хаягдалын хураамж төлөгч	Хэмжих нэгж	Төлбөрийн хэмжээ
1	Иргэн	Сард	500
2	Төсвийн байгууллагууд	Сард	20'000
3	Банк /салбар/	Сард	30'000
4	Хүнс барааны дэлгүүр, цех /Дугуй засвар, Гутал засвар, талх, биллард/	Сард	30'000
5	Цайны газар	Сард	30'000
6	Эмийн сан	Сард	30'000
7	Шатахуун түгээх станц	Сард	30'000
8	Уул уурхайн газар үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллага	Ашиглалт	Сард 250'000
		Хайгуул	Сард 100'000
9	Аж ахуйн нэгж байгууллага /Өртөө, Чандмань Илч ОНӨХК, Цахилгаан түгээх станц г.м/	Сард	30'000

*Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2026 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн
08/03 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт*

**ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫГ АЧИХ, ТҮРЭХ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНЭ ТАРИФ**

Үзүүлэлтүүд		Нэгж	Тооцоолол /DFAG DONG машин/	Тооцоолол /30 Ковш/
1.	Нэг рейсийн тээвэрлэлтийн дундаж зай	км	9 км	9
2.	Хөдөлгөөний үеийн шатахуун зарцуулалтын норм	Км/л	0,20	18
3.	Нэг рэйсд хийх хөдөлгөөний үеийн шатахуун зарцуулалтын дундаж	км/л	0.02	1.62
4.	Ачилтын үеийн шатахуун зарцуулалтын норм	Мин/л	0.02	0.3
5.	Ачилтын үеийн цаг ашиглалт	Мин	105	105
6.	Ачилтын үеийн шатахуун зарцуулалт	Мин/л	2.1	31.5
7.	Шатахууны үнэ	Төг/л	3770	3770
8.	Нэг рейст зарцуулах шатахуун	Төг/л	7992.4	124862.4
9.	Ажиллах хугацааны үндсэн цалин	Төг/рейс	45428.5	45428.5
10.	Ажилтны багаж хэрэгсэл	Төг/рейс	20000	20000
11.	Нэг рейсд шаардагдах зардал	төг/рэйс	128420.9	240087.9
12.	Тээврийн хэрэгслийн элэгдлийн зардал	Төг/рейс	10662.6	16406.25
13.	Тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээний зардал	Төг/рейс	2100	0
14.	Нэг рейст ачиж тээвэрлэх хогийн дундаж хэмжээ	төг/Тн	2.5 тн	1.5
15.	Нэг тонн хогийг тээвэрлэх зардал	Тн/төг	35000	150000

ЗАВХАН АЙМГИЙН НӨМРӨГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 3 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар 04

Хөдрөг

ХОГ ХАЯГДЛЫН ТӨЛБӨР ХУРААМЖ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10, 48 дугаар зүйлийн 48.1 дэх заалт, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2 дахь заалтыг үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Хөрсний бохирдлыг багасгах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хог хаягдлыг цэвэрлэж тээвэрлэх зорилгоор аж ахуйн нэгж, албан байгууллага, үйлдвэрлэл үйлчилгээ явуулдаг газруудаас хураах төлбөр хураамжийн хэмжээг хавсралтаар тогтоосугай.

2.Батлагдсан үйлчилгээний хураамжийг сумын төвд байрлаж буй айл өрх, аж ахуйн нэгж албан байгууллагыг хамруулж татварын орлогыг сумын татварын орлогын дансанд төвлөрүүлэн, зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг сумын Засаг дарга (Н.Дашдондовт)-д даалгасугай.

3.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (П.Бадамханд)-д даалгасугай.

4.Энэхүү тогтоолыг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтэлсний дараа дагаж мөрдсүгэй.

ДАРГА

З.БАЯРМАГНАЙ

*Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
2026 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн
04 дүгээр тогтоолын хавсралт*

ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭ

№	Үйлчилгээний төрлүүд	Хэмжих нэгж /Нэг сарын хураамж/	Хураамж /төгрөгөөр/
1	Айл өрх	Нэг сарын хураамж	1,000
2	Сумын төвд мал тэжээдэг өрхөөс	Малтай нохойтой	Нэг сарын хураамж 2000
		Малгүй нохойтой	Нэг сарын хураамж 1250
3	Авто угаалга, дугуй засвар	Нэг сарын хураамж	5,000
5	Хүнс барааны дэлгүүр	Нэг сарын хураамж	6000
6	Ил задгай талбайд худалдааны үйл ажиллагаа эрхлэгч дэлгүүр, баяр наадмын үеэр барьсан цайны газар бусад цэгүүд	Үйл ажиллагаа явуулсан сар бүр	10,000
7	Төсөвт байгууллага	Нэг сарын хураамж	6000
8	Халуун усны, Үсчин гоо сайхан	Нэг сарын хураамж	5000
9	Зочид буудал, Гуанз	Нэг сарын хураамж	6000
10	Шатахуун түгээх станц	Нэг сарын хураамж	10000
11	Мал амьтны түүхий эд авах цэг	Нэг сарын хураамж	2000
12	Уурын зуух	Нэг сарын хураамж	25000
13	Paradise	Нэг сарын хураамж	10000
14	Хаан банк	Нэг сарын хураамж	2500
15	Төрийн банк	Нэг сарын хураамж	2500
16	Эрчим хүч	Нэг сарын хураамж	6000
17	Цаг уур	Нэг сарын хураамж	6000

ТӨВ АЙМГИЙН АЛТАНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 3 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар 09

Туул

МАЛЫН ТОО ТОЛГОЙН АЛБАН ТАТВАР ТОГТООХ ТУХАЙ

Сумын малын тоо толгойн албан татварын хэмжээ тогтоох тухай сумын Засаг дарга Д.Батсуурийн мэдээлэл, өргөн мэдүүлсэн төсөл, түүнд Хурлын Эдийн засаг, төсөв санхүүгийн хорооноос хийсэн дүгнэлтийг хэлэлцээд, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14, 48 дугаар зүйлийн 48.1, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, 6.4, Татварын ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Сумын 2025 оны жилийн эцэст тоологдсон малчин, мал бүхий этгээдийн нэг толгой малд ногдуулах албан татварын хэмжээг дор дурдсанаар тогтоосугай.

Тэмээ 0

Адуу 0

Үхэр 0

Хонь 0

Ямаа 0

2.Сумын 2026 оны төсөвт Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн 100,000,000 (нэг зуун сая) төгрөгийн хөрөнгө оруулалтын зардлыг 2020-2023 оны малын тоо толгойд ногдуулсан татварыг төлөөгүй малчин, мал бүхий иргэдийн татварын өр 201,951,100 (хоёр зуун нэг сая есөн зуун тавин нэгэн мянга нэг зуу) төгрөгийг төвлөрүүлж Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.8-д заасан зориулалтаар зохих журмын дагуу зарцуулахыг сумын Засаг дарга (Д.Батсуурь)-д даалгасугай.

3.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Эдийн засаг, төсөв санхүүгийн хороонд үүрэг болгосугай.

4.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн бүртгэлийн 7224 дугаарт бүртгэлтэй сумын ИТХ-ын 2025 оны 02 сарын 18-ны 08 дугаар тогтоолыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2026 оны 4 дүгээр
сарын 15-ны өдөр

Дугаар 12

Мөрөн
сум

ХӨВСГӨЛ АЙМГИЙН УСНЫ САН БҮХИЙ ГАЗАР, УСНЫ ЭХ ҮҮСВЭРИЙН ОНЦГОЙ БОЛОН ЭНГИЙН ХАМГААЛАЛТЫН БҮСИЙН ХИЛИЙН ЗААГИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2, Усны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4, 22 дугаар зүйлийн 22.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.4 дэх заалт, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны 2026 оны 03/1375 тоот албан бичгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Хөвсгөл аймгийн нутаг дэвсгэр дэх усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын бүсийн талбайн хэмжээг 01 дүгээр хавсралтаар, усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын бүсийн хилийн заагийн солбицлыг 02 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын бүсийн хилийн заагийг газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд оруулахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Х.Идэр)-д, улсын усны нэгдсэн мэдээллийн санд бүртгүүлэхийг аймгийн Байгаль орчны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Т.Лхагвадорж)-д, Усны тухай хууль, “Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам”-ын дагуу үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Батлагдсан тогтоолыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, “Захиргааны хэм хэмжээний акт”-ын Улсын нэгдсэн санд бүртгүүлэх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Будсүрэн)-д даалгасугай.

4.Энэхүү тогтоолыг Захиргааны хэм хэмжээний актын Улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэний дараа мөрдөж ажилласугай.

5.Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн ээлжит IX хуралдааны 09 дүгээр тогтоолын 01 дүгээр хавсралт, 02 дугаар хавсралтын усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүсийн хилийн заагтай холбогдох хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

6.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар 05-ны өдрийн 90 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Д.ПҮРЭВДОРЖ

Энэ тогтоолын хавсралтыг доорх линкээр үзнэ үү.
<https://legalinfo.mn/mn/detail?lawId=17436671668952>

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2026 оны 3 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар 106

Улаанбаатар
хот

ЖУРАМД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.2.5, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 286 дугаар тогтоолоор баталсан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт”-ийн 6.2 дахь хэсгийн “Хороонд” гэсний дараа “цахимаар” гэж нэмсүгэй.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын албанд даалгасугай.

ДАРГА

Т.ЖАМБААЖАМЦ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2026 оны 3 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар 107

Улаанбаатар
хот

ЖУРАМД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 233 дугаар тогтоолоор баталсан “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам”-ын 5.1 дэх хэсгийн “болон албан бичгээр” гэснийг хассугай.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын албанд даалгасугай.

ДАРГА

Т.ЖАМБААЖАМЦ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2026 оны 3 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар 108

Улаанбаатар
хот

ЖУРАМД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

